



**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027
И-мэйл: info@fchm.edu.mn

2025.06.13 № 1/959
танай _____-ны № _____-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗАРТ

Тайлан хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 тоот тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу УНТЭ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 56 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.БЯМБАСҮРЭН

142251564

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая. төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
ЗОРИЛГО: ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛЖ, ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ, ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАН БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ, САНХҮҮГИЙН ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ							
ЗОРИЛТ 1: Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх							
1.1	ЗГҮАХ 2.3.4.1 Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалтад орсон меньерийн өвчний хүнд хэлбэрийн үеийн мэс заслыг нэвтрүүлэх хүний нөөцийг сургаж бэлтгэнэ.	-	Бэлтгэгдсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	-	1-2 эмч бэлтгэгдсэн байна	ЧХХСМЗТ-ийн эмч 3.Мэндсайхан Малайз Улсын Малай их сургуулийн эмнэлэгт 3 сарын хугацаатай Меньерийн өвчний хүнд хэлбэрийн үеийн мэс засал эмчилгээний чиглэлээр суралцаж байна.	90%
1.2	МУХТ 3.3.11 Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний тохиолдлыг бууруулах зорилгын хүрээнд тулгуур эрхтний төрөлхийн дутуу хөгжил, олдмол гажиг, эмчлэхэд төвөгтэй согогуудад сэргээн засах мэс заслыг хийнэ.	16.0 (эрүүл мэндийн даатгал)	Хийгдсэн мэс заслын тоо	Эмчийн баг бэлтгэгдсэн, тоног төхөөрөмжтэй	3 тохиолдолд амжилттай хийсэн байна.	Том хэмжээний ясны дутмагшлын үед мөч хадгалах мэс засал 2 удаа хийгдсэн. Мөн ХҮСҮСТ-ийн эмч нар төвөгтэй согог сэргээх чиглэлээр гарын хурууны шивнүүрийн үе солих шаардлагатай үйлчлүүлэгч нарыг бэлтгэж эхэлсэн бөгөөд тус мэс заслаар 2 эмчийг ХБНГУ-д сургасан. Хурууны хиймэл үеийг даатгалд хамруулан мэс заслыг хийхээр төлөвлөсөн.	90%

1.3	МУХТ 3.3.11 Төвлөрлийг бууруулах, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хүзүүний хорт хавдрын нээлттэй мэс заслын тусламж үйлчилгээг эхлүүлнэ.	45.0 (эрүүл мэндийн даатгал)	- Хийгдсэн мэс заслын тоо - Бэлтгэл ажлын тайлан	-	3-5 тохиолдолд амжилттай хийсэн байна.	2025.04.09-нд УНТЭ-ийн ЧХХСМЗТ-т төвөнх бүтэн авах, хүзүүний тунгалгийн булчирхай түүх хавдрын мэс заслыг АУ-ны доктор С.Нэргүй ахлагчтай төвөнх, залгиурын баг хавдрын зөвлөх эмч Г.Пүрэвдоржтой хамтран 1 тохиолдолд амжилттай хийсэн.	90%
1.4	МУХТ 3.3.11 Цусны ба Хэрх, үений эмгэгийн тусламж үйлчилгээг дүүрэг болон бүсийн оношилгоо, эмчилгээний төвд үзүүлэх эмч нарыг сургаж бэлтгэнэ.	-	- Сургаж бэлтгэсэн эмч, мэргэжилтний тоо - Тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчийн тоо	Сургалт зохион байгуулах бүрэн боломжтой	2-3 дүүрэг, 1-2 БОЭТ-д Цусны ба Хэрх, үений эмгэгийн тусламж үйлчилгээг үзүүлдэг болсон байна.	Төвлөрлийг сааруулах ажлын хүрээнд ЦЭСЧШСТ нь аймаг, дүүрэгт цусны эмч бэлтгэх зорилгоор дараах хөтөлбөрүүдийг боловсруулж, салбар зөвлөлөөрөө хэлэлцүүлэн ЭМХТ-д хүргүүлсэн. Үүнд: 1. Хүний их эмчийн “Үүдэл эс шилжүүлэн суулгалт” мэргэжил дээшлүүлэх 3 сарын хөтөлбөр 2. Хүний их эмчийн “Цус судлал” мэргэжил дээшлүүлэх 3 сарын хөтөлбөр Мөн ХҮСҮСТ-өөс хүний их эмчийн “Хэрх, үе судлал” мэргэжил дээшлүүлэх 3 сарын сургалтын хөтөлбөрийг боловсруулан СЭШХАА-нд хянагдаж байна.	30%

1.5	Хоол боловсруулах замын дурангийн сургалтын төв байгуулах төслийг эхлүүлж бэлтгэл ажлыг хангана.	-	- Сургалтын хөтөлбөр, төсөв - Төлөвлөсөн арга хэмжээ	3 багш эмчтэй	Тухайн жилийн төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	Гастроэнтерологийн төвийн эмч нар дурангийн сургалтын төв байгуулах төслийг англи, монгол хэл дээр бэлтгэж, 4 байгууллагад цахимаар хүргүүлсэн. Мөн ЭМЯ-ны төвлөрлийг сааруулах хөтөлбөрийн төсөлд хүргүүлэхээр бэлтгэж байна.	30%
1.6	Сүхбаатар дүүргийн “Сэлбэ” нэгдсэн эмнэлгийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах, салбар эмнэлгийн хэмжээнд хөгжүүлнэ.	-	- Сургасан эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтний тоо - Мэргэжил арга зүйгээр хангасан чиглэл	-	Эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, мэс заслын тусламж үйлчилгээг эхлүүлсэн байна.	УНТЭ-ийн удирдлагын баг нь Сүхбаатар дүүргийн Сэлбэ нэгдсэн эмнэлэгтэй 2025.04.16-нд УНТЭ 39/25 дугаартай хамтын ажиллагааны санамж бичиг зурсан. Тус гэрээний дагуу эхний суралцах эмч, сувилагч нарын нэрс ирсэн бөгөөд сургах бэлтгэл бүрэн хангагдсан.	50%
1.7	Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлгийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.		Хийгдсэн мэс заслын тоо, төрөл	2022 онд хамтын ажиллагааны гэрээ байгуулсан	Мэс заслын тоо болон төрлийг нэмэгдүүлсэн байна.	Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлгийг мэргэжил арга зүйгээр хангах хамтын ажиллагааны гэрээ хийх ажил хэлцлийн шатанд байна. Хамтран ажиллах гэрээний хүрээнд 5 чиглэлээр Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлгийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.	30%

ЗОРИЛТ 2: Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах

2.1	ДОТ-ийн Цөмийн онош зүйн хэсэгт Олон улсын атомын энергийн газрын дэмжлэгтэй Спект СТ аппаратыг хүлээн авч суурилуулан ашиглалтад оруулна.	3,000.0 ОУАЭГ	– Гэрээ – Ашиглалтад оруулсан акт - Үйлчлүүлсэн иргэдийн тоо	Ханган нийлүүлэх гэрээ байгуулагдсан .	Спект СТ аппарат үйл ажиллагаанд орж нийт 1000 орчим иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.	Олон улсын атомын энергийн газрын дэмжлэгтэй хэрэгжиж буй МОН/6023 төслийн хүрээнд УНТЭ-т суурилагдах Спект СТ аппарат нь 2025 оны 05 сарын 21-ны өдөр эмнэлэгт ирсэн. 2025.06.11-ний өдөр Унгар улсаас суурилуулалтын инженер хүрэлцэн ирж суурилуултын ажил эхэлсэн.	70%
2.2	Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагааг сайжруулна.	-	- Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	ЭМС-ын 2024 оны А/112 тоот “Журам батлах тухай” тушаал	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	ЭМТҮЧАБА-наас үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор: 1. “Хэцүү үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээ” 2. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ” 3. “Мэс заслын тусламж үйлчилгээний журам”-ыг шинээр боловсруулан батлуулж нийт эмч, сувилагч эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэдээлсэн. Өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Эмнэлгийн хэмжээний чанарын багийг 80	90%

						гишүүнтэй болгон өргөжүүлж, тусламж үйлчилгээний чанар, хууль тогтоомж, эрсдлийн удирдлагын чиглэлээр нийт 5 удаагийн сургалт зохион байгуулж, чанарын багийн гишүүдийг 80 болгон өргөжүүлж, эрсдэлийн бүртгэл хийх үйл ажиллагааг тогтмолжуулсан.	
2.3	Амбулаториор хийгддэг мэс ажилбар, үйлдлийн явцад мэдээгүйжүүлэг, ажилбарын үеийн тайвшруулалт хийх үйл ажиллагааны журам батлуулж мөрдөн ажиллана.	-	- Эмнэлгийн захирлын тушаалаар батлагдсан журам - Хэрэгжилтийн тайлан	Журам батлагдаагүй	Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж хэвшсэн байна.	ЭМТҮЧАБА, МХНТ хамтран “Амбулаториор хийгддэг мэс ажилбар, үйлдлийн явцад мэдээгүйжүүлэг, ажилбарын үеийн тайвшруулалт хийх үйл ажиллагааны журам” боловсруулсан. Тус журам нь 11 бүлэг 2 хавсралтаас бүрдсэн бөгөөд хэлэлцүүлгийн шатанд байна.	50%
2.4	Харилцааны бэрхшээлтэй буюу аман харилцаа үүсгэх боломжгүй үйлчлүүлэгчийг таних аргыг нэвтрүүлж, холбогдох журмын хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Хяналтын тайлан болон хяналтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	Эмнэлгийн захирлын 2024 оны А/99 тоот тушаалаар журам батлагдсан	Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж хэвшсэн байна.	“Сонсголгүй иргэдийн үндэсний холбоо”, УНТЭ-ийн НЭМА, СЗУЭТ-ууд хамтран 2025.05.26-ний өдрөөс “Харилцааны анхан шатны дохионы хэл” 3 удаагийн 12 багц цагийн сургалтыг зохион байгуулж, нийт 29 эмч, сувилагч, эмнэлгийн	100%

						мэргэжилтнүүдийг хамруулсан.	
2.5	Өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эмийн аюулгүй байдлыг хангах, хяналтыг сайжруулах, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.	-	Хяналтын тайлан болон хяналтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	Тогтмол зохион байгуулагддаг	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	Эмзүйн албанаас эмнэлгийн хэмжээнд хэрэглэгдэж буй 1. Сонгодог өндөр эрсдэлт эм, 2. Ижил дуудагддаг өндөр эрсдэлт эм, 3. Ижил харагддаг өндөр эрсдэлт эмийн мэдээллээр таниулах зурагт хуудас бэлтгэн цахимаар болон нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний яриан дээр мэдээллийг хүргэн ажиллаж байна. Мөн ижил савлагаатай, адил харагддаг эмийн нэгж тунгийн савлагаан дээр анхааруулах тэмдэг наан хяналт тавин ажиллаж байна.	90%
2.6	ОЭТН-ийн халдварыг бууруулах, тандалт хяналтыг сайжруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ.	-	Хяналтын тайлан авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	Хийгдэж байсан	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	2025 оны эхний хагас жилд Эмнэлзүй, эмгэг судлалын нэгдсэн лабораторт хийгдсэн нян судлалын шинжилгээгээр ОЭТН-ийн нийт 453 эерэг сорьц илэрснийг шуурхай мэдээлэх тогтолцооны дагуу ХСХА-нд мэдээлсэн. Үүнд: ➤ Амбулаторид-162	90%

						➤ Яаралтай тусламжийн тасагт-32 ➤ Дотрын тасагт-108, ➤ Мэс заслын тасагт-151. Үүнээс хэвтэн эмчлүүлэх тасагт илэрсэн 259 тохиолдлоос ЭТҮХХ-ын сэжигтэй, олон эмэнд тэсвэртэй нянгийн 25 тохиолдолд тандалт судалгааг хийж ХӨСҮТ-д сэжигтэй тохиолдлоор мэдээлээд байна. <i>Дэлгэрэнгүй тайланг хавсралт тайланд тусгасан.</i>	
2.7	Үйлчлүүлэгчийг дэмжих алба байгуулна.	-	– Батлагдсан тушаал – Шийдвэр – Ажиллах дүрэм	-	Үйлчлүүлэгчийг дэмжих албатай болсон байна.	“УНТЭ-ийн дүрмийг шинэчлэн батлуулах хүсэлт болон дүрмийн шинэчилсэн төсөл”-ийг 2025 оны 06 дугаар сард ЭМЯ-нд хүргүүлсэн бөгөөд шинэчлэгдсэн дүрмийн дагуу батлагдах бүтцэд “Үйлчлүүлэгчийг дэмжих алба”-ыг байгуулан ажиллахаар төлөвлөсөн.	30%
2.8	“Сувилагчийн нэг өдөр” аян, өдөрлөгийг зохион байгуулна.	-	Өдөрлөгийн удирдамж, тайлан	Жил бүр зохион байгуулагддаг	Өдөрлөг зохион байгуулагдсан байна.	Олон Улсын сувилагчийн өдрийг угтаж Сувилахуйн албанаас сувилагч нарын мэргэжил, үйл ажиллагааг суртачлах зорилго бүхий аяныг зохион байгуулж, аяны хүрээнд Reel видео бичлэгийн уралдааныг	100%

						зохион байгуулсан. Мөн mass.mn , arslan.mn мэдээллийн цахим хуудсуудтай хамтран шилдэг сувилагч нарынхаа талаар мэдээ контент бэлтгэн ард иргэдэд хүргэсэн.	
ЗОРИЛТ 3: Санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, нөөцийн удирдлагыг сайжруулах							
3.1	Эмнэлгийн e-Health, VERITECH ERP санхүүгийн системүүдийг өгөгдөл солилцдог болгож улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн хөгжүүлэлтийг программд хийнэ.	20.0 (үйл ажиллаг ааны орлого)	- Хийсэн ажлын тайлан - Хөгжүүлсэн модулийн тоо - Акт дүгнэлт	Эм эмнэлгийн хэрэгсэл, хоол, угаалгын зардлыг механик аргаар бүртгэдэг	Үйлчлүүлэгчийн зардлыг VERITECH ERP санхүүгийн системд харилцагч, онош тасгаар шууд хөрвүүлдэг болсон байна	VERITECH ERP санхүүгийн системд агуулахын бүртгэлийн систем шинээр худалдан авч, программын хөгжүүлэлт хийж буйтай холбоотой техникийн тодорхойлолтыг боловсруулж, худалдан авалтыг зохион байгуулж байна. Ингэснээр эмийн орлого зарлага нь оношоор болон өвчтөнөөр тайлан гардаг болох бөгөөд эм, эмнэлгийн хэрэгсэл баркодын системд бүрэн нэвтэрнэ.	70%
3.2	ЭМДЕГ-тай байгуулсан тусламж үйлчилгээ худалдах, худалдан авах гэрээнд үндэслэн эмнэлзүйн төв, тасгуудын орлого зарлагыг тооцож, нотолгоонд суурилсан төлөвлөлт хийн ажиллана.	-	- Хийгдсэн тооцоолол, төлөвлөлт - Төв, тасгийн дарга, эрхлэгч нартай байгуулсан үр дүнгийн гэрээ	ЭМДЕГ-тай байгуулсан гэрээ	Орлого, зарлагын төлөвлөлтийг хянаж удирдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	ЭМДЕГ-тай байгуулсан гэрээний дагуу төлөвлөлтийг хийн, нийт тасаг нэгжийн эрхлэгч, дарга нартай 4 удаагийн уулзалт зохион байгуулж, танилцуулсан.	50%

3.3	Амбулаторийн эмийн сангийн тусламж үйлчилгээг өргөжүүлнэ	300,0 (үйл ажиллаг ааны орлого)	- Нэгж тунгийн системээр эм олгогдсон үйлчлүүлэгчийн тоо - Борлуулалт хийсэн мөнгөн дүн	-	Амбулаторийн эмийн сангийн орлогыг 15-20%-аар нэмэгдүүлсэн байна.	Амбулаторийн эмийн сангийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, өөрийн орлогоо нэмэгдүүлэх тооцооллыг 2025.05.20-ны өдрийн ТУЗ-ийн хуралд танилцуулсан.	30%
3.4	Нийт эмнэлзүйн төв, тасгуудад нэхэмжлэлийн хяналтын шалгуурын дагуу явцын болон төлөвлөгөөт хяналт хийх, хяналтын үр дүнд гарсан алдаа зөрчлөөс сэргийлсэн сургалт, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулна.	-	- Хяналт хийсэн тоо, төрөл - Хяналтын тайлан - Авсан арга хэмжээ	2024 онд нийт хасагдлын 4%	Нийт хасагдлыг 3.5% болгон бууруулах	ЭМДҮЗ-н 2022 оны 12 дугаар тогтоолын дагуу явцын хяналтыг тасралтгүй хийж байна. Гарсан зөрчлийг холбогдох төв, тасагт мэдээлж тухай бүрд залруулан ажиллаж байна. 2025 оны эхний 3 сарын байдлаар нийт хасагдал 50%, эмнэлзүйн шалгуур хангаагүй хасагдал 40%-р тус тус буурсан байна.	70%
3.5	Амбулаторийн хэсэгт архаг өвдөлт намдаах тусламж үйлчилгээг үзүүлнэ.	-	-Журам -Тусламж үйлчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	-	Амбулаторийн хэсэгт архаг өвдөлтийн тусламж үйлчилгээг үзүүлдэг болсон байна.	МХНТ-ийн их эмч А.Мягмар Тайвань улсад архаг өвдөлтийн эмчилгээний чиглэлээр суралцаж байна.	30%
ЗОРИЛТ 4: Оношилгоо, эмчилгээ, сувилахуйн дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэн нутагшуулах							
4.1	Бөөрний реципиентэд дурангаар бөөр шилжүүлэн суулгах шинэ технологийг нэвтрүүлнэ.	-	Амжилттай хийсэн мэс заслын тоо	Мэргэжлийн баг бэлтгэгдсэн	1-2 тохиолдолд амжилттай хийсэн байна	Одоогоор эмч болон бусад мэргэжилтнийг сургах үе шатанд ажиллаж байна.	30%
4.2	Донорын элгийг дурангаар тайрах мэс заслын технологийг нэвтрүүлнэ.	-	Амжилттай хийсэн тохиолдлын тоо	МУ-д анх удаа хийгдэнэ	1-2 тохиолдолд амжилттай хийсэн байна	2025.02.22-ны өдөр Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн элэг шилжүүлэн суулгах	

						мэс заслын баг БНСУ-ын Асан эрүүл мэндийн төвийн эмч нартай хамтран донорын мэс заслыг хэвлийн дурангийн аргаар анх удаа 1 тохиолдолд амжилттай хийсэн.	100%
4.3	Нүдний даралт ихсэх өвчний үед хийгддэг MIGS мэс заслыг нэвтрүүлж, нутагшуулна.		Амжилттай хийгдсэн тохиолдлын тоо	Гадны эмч нартай хамтарч хийдэг	3-5 үйлчлүүлэгчид мэс засал хийсэн байна.	УНТЭ-ийн HCM3T-ийн эмч нар Австралийн Sight For All сангийн глаукомын эмч, зочин профессоруудтай хамтран 2025 оны 06 сарын 10-ны өдөр нүдний даралт ихсэх өвчний үед хийгддэг бичил хүрцэт /MIGS/ мэс заслыг 1 тохиолдолд амжилттай хийсэн.	100%
4.4	Хоол боловсруулах замын дурангийн эмчилгээний шинэ аргыг тусламж үйлчилгээнд нэвтрүүлнэ. - Дурангаар ходоодны хавдрыг бүх давхаргаар бүтнээр нь хуулах (EFTR)	-	Амжилттай хийсэн тохиолдлын тоо	Эмч бэлтгэгдсэн, дурангийн тоног төхөөрөмжтэй	1-2 үйлчлүүлэгчид эмчилгээг хийсэн байна	Тус эмчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгслийг захиалгад оруулсан.	30%
4.5	Төвөнх, залгиур, толгой хүзүүний лазерын эмчилгээг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлнэ.	-	- Бэлтгэгдсэн эмч нарын тоо - Бичигдсэн төсөл	-	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	ЧХХСМ3Т-ийн 2 эмч хавдрын чиглэлээр суралцаж байна. Лазер эмчилгээний төсөл бичсэн.	30%

4.6	Толгой, хүзүүний хорт хавдрын дурангийн мэс заслыг эхлүүлнэ.	–	- Амжилттай хийгдсэн эмчилгээний тоо - Бэлтгэгдсэн эмч, мэргэжилтний тоо	-	5 тохиолдолд мэс засал хийсэн байна.	2025 оны эхний хагас жилд Чих хамар хоолой, мэс заслын тасгийн их эмч Н.Ган-Эрдэнэ УХТЭ-ийн Чих хамар, хоолой, хүзүү толгойн мэс заслын тасгийн эмч нартай хамтран хамрын дайвар хөндий болон хамрын хөндийн хорт хавдрыг дурангаар авах мэс заслыг 2 тохиолдолд, хүзүүний тунгалгийн булчирхай түүх хавдрын мэс заслыг 1 тохиолдолд тус бүр амжилттай хийсэн. Хүзүү толгойн хавдрын мэс заслын чиглэлээр 2 эмч бэлтгэгдсэн.	90%
4.7	Хорт хавдартай өвчтөнүүдийн ясны үсэрхийллийн өвдөлт намдаах эмчилгээг шинээр нэвтрүүлнэ.	–	–Эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	-	5 тохиолдолд амжилттай хийсэн байна.	Тус эмчилгээнд хэрэглэгдэх химийн холбогч бодис болон цацраг идэвхт изотопын үнийн судалгааг хийсэн.	30%
4.8	Үгийн аудиометрийн шинжилгээг оношилгоонд нэвтрүүлж үндэсний хэмжээнд хөгжүүлнэ.	Төсөл, хөтөл бөр	- Стандарт батлагдсан байна - Оношилгоонд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	-	50 үйлчлүүлэгчид хийсэн байна.	ЧХХСМЗТ-ийн сонсголын багийн эмч нар тус стандартыг боловсруулан УНТЭ-ийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, ЭМЯ-нд хүргүүлсэн. Одоогийн байдлаар стандартыг “Стандарт хэмжилзүйн газар”-ын цахим хуудаст байршуулан, санал авч байна.	70%

						https://estandard.gov.mn/web/site/news.aspx?id=144	
4.9	Гуурсан хоолойн уян дурангаар захын байрлалтай үүсгэврээс эдийн шинжилгээ авна.		- Амжилттай хийсэн тохиолдлын тоо	Эмч мэргэжилтэн бэлтгэгдсэн	5-10 тохиолдолд оношилгоог амжилттай хийгдсэн байна.	Уушги, харшил судлалын төв нь 2025 оны эхний хагас жилийн байдлаар 5 тохиолдлыг амжилттай хийсэн.	100%
4.10	МУХТ 3.3.16 ICT TENS буюу өвдөлт намдаах зорилгоор ашигладаг цахилгаан эмчилгээний аппаратыг сэргээн засах эмчилгээнд нэвтрүүлнэ.	13.0 (төсөл хөтөл бөр)	- Бичигдсэн төсөл - Санхүүжилтийн тайлан	-	Төсөл хэрэгжиж аппарат суурилагдсан байна	Тухайн аппаратын хэрэгцээ шаардлагын судалгааг Сэргээн засах эмчилгээний тасгаас Ерөнхий захиралд танилцуулсан.	30%
4.11	Ходоод, бүдүүн шулуун гэдэс, хөх, өндгөвч болон бусад хавдрын оношилгоонд шаардлагатай 113 гений мутаци тодорхойлох шинжилгээг бүрэн нутагшуулна.	40.0 (үйл ажиллаг ааны орлого)	Шинжилгээ, оношилгоонд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	2024 онд 4 тохиолдолд хийсэн.	Оношилгоог нийт 10 үйлчлүүлэгчид хийсэн байна.	2025 оны 3, 4-р улиралд шинжилгээг хийхээр төлөвлөж байна.	-
4.12	Үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээг хийхэд шаардлагатай HLA typing 11 локуст тодорхойлох шинжилгээг NGS технологи iSeq 100 төхөөрөмж дээр хийж гүйцэтгэнэ.	100.0 (үйл ажиллаг ааны орлого)	Шинжилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	2024 онд 15 тохиолдолд хийсэн.	Оношилгоог нийт 40 үйлчлүүлэгчид хийсэн байна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 80 үйлчлүүлэгчид хийсэн.	100%

4.13	Мөгөөрсний гэмтлийг үүдэл эс ашиглан эмчлэх технологийг нэвтрүүлнэ.	–	Амжилттай хийгдсэн тохиолдлын тоо	УНТЭ-д мезенхимийн үүдэл эс ялгах эмчилгээ хийгдэж байгаагүй	1-2 тохиолдолд амжилттай хийсэн байна.	2025 оны 05 дугаар сард БНСУ-н Medrex үүдэл эсийн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээг байгуулсан. Тус хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын эмч нар ХҮСҮСТ-ийн нийт эмч нарт сургалт явуулсан.	30%
4.14	Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын дархлаа эмчилгээг нэвтрүүлж нутагшуулна.	20.0 (үйл ажиллаг ааны орлого)	Амжилттай хийгдсэн тохиолдлын тоо	Эмч, мэргэжилтэн бэлтгэгдсэн	5-10 тохиолдолд амжилттай хийсэн байна.	Хорт хавдрын дараах дархлаа эмчилгээг хийх бүрэн тогтолцоо бүрдсэн. Хими эмчилгээний 2 эмч бэлтгэсэн, тус эмчилгээнд хэрэглэгдэх дархлааны эмүүдийг 2025 оны эмийн захиалгад оруулсан.	70%
4.15	Гамма пробыг хөх хадгалах, хавдрын хагалгаа болон бамбайн дэргэдэх булчирхайн байршлыг мэс заслын үед ашиглан илрүүлж хагалгаа, эмчилгээний менежментийг сайжруулах технологийг нэвтрүүлнэ.	-	Эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	-	10 тохиолдолд амжилттай хийсэн байна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 5 мэс ажилбар хийгдсэн.	90%
4.16	Элэгний анхдагч хавдрын тэжээгч судсаар бөглөх эмчилгээнд химийн тариа ялгаруулагч бөмбөлөг материалаар бөглөх эмчилгээг практикт нэвтрүүлнэ.	-	Эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	-	5 тохиолдолд амжилттай хийсэн байна.	2025 оны 1 дүгээр улирлаас эхлэн эмнэлзүйд нэвтрүүлж эхэлсэн бөгөөд эхний хагас жилийн байдлаар 3 тохиолдолд drug eluting beads ашиглан TACE эмчилгээг хийсэн.	90%

4.17	Элэг шилжүүлэн суулгах эмчилгээний зааврыг шинэчлэн батлуулна.	-	ЭМС-ын тушаалаар батлагдсан эмчилгээний заавар	ЭМС-ын 2014 оны “Заавар батлах тухай” 177 тоот тушаал	Эмчилгээний заавар зохих хурлуудаар хэлэлцэгдэн ЭМЯ-нд хүргэгдсэн байна.	Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн элэг шилжүүлэн суулгах багийн эмч нар элэг шилжүүлэн суулгах эмчилгээний зааврыг шинэчлэн боловсруулсан. Тус зааврыг УНТЭ-ийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, ЭМЯ-нд хүргүүлсэн.	70%
4.18	Бөөр шилжүүлэн суулгах эмчилгээний зааврыг шинэчлэн батлуулна.	-	ЭМС-ын тушаалаар батлагдсан эмчилгээний заавар	ЭМС-ын 2014 оны “Заавар батлах тухай” 74 тоот тушаал	Эмчилгээний заавар зохих хурлуудаар хэлэлцэгдэн ЭМЯ-нд хүргэгдсэн байна.	Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн бөөр шилжүүлэн суулгах багийн эмч нар эмчилгээний зааврыг шинэчлэн боловсруулж, УНТЭ-ийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлтгэж байна	30%
4.19	Хорт хавдрын дараах бай эмчилгээнүүдийг өөрийн эмнэлэгт бүрэн нутагшуулна - Хэрх үений бай эмчилгээ - Цусны хавдрын бай эмчилгээний 2-3 дугаар эгнээний 1-2 бай эмчилгээ	-	Амжилттай хийгдсэн тохиолдлын тоо	Эмч, мэргэжилтэн бэлтгэгдсэн	5-10 тохиолдолд амжилттай хийсэн байна.	Цусны хавдрын бай эмчилгээний 2-3 дугаар эгнээний эмчилгээ болох Акалабрутиниб эмийг 2 тохиолдолд, Понатиниб эмийг 2 тохиолдолд шинээр эмчилгээнд нэвтрүүлж, үр дүнг хянаж байна.	70%
4.20	Хэвлийн дурангийн болон толгой, хүзүү, урологийн, ерөнхий мэс заслын хорт хавдрын үеийн лимфдиссекшн технологиудыг	-	Амжилттай хийгдсэн тохиолдлын тоо	Эмч, мэргэжилтэн бэлтгэгдсэн	Нийт 10-аас доошгүй тохиолдолд амжилттай хийсэн байна.	Хүзүүний лимфдиссекшн 1 тохиолдол, хэвлийн дурангаар бөөр авах, булчирхай түүх мэс засал эмчилгээг 3 тохиолдолд тус тус хийж шинэ технологи нэвтрүүлсэн.	70%

	тусламж үйлчилгээнд нэвтрүүлнэ.						
4.21	Хорт хавдрын дараах хими эмчилгээг өөрийн эмнэлэгт хийж, 10 ортой нэгж байгуулна.	-	- Нэгж байгуулсан тушаал, журам - Хими эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо - Хими эмчилгээний төрөл	7 чиглэлээр 1200 удаагийн сеанс хими эмчилгээ хийгдсэн байна.	Нэгж байгуулагдаж, хорт хавдрын дараах тусламж үйлчилгээний төрөл болон тоон үзүүлэлтийг нэмэгдүүлсэн байна.	Ерөнхий мэс заслын тасагт хорт хавдрын дараах хими эмчилгээний 10 ортой нэгж байгуулан, БШГМЗТ-ийн эрхлэгч Э.Бат-Өлзий эмч хариуцан ажиллаж байна.	90%
ЗОРИЛТ 5: Хүний нөөцийн хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх							
5.1	Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ бусад холбогдох журмыг шинэчлэн батлуулж ажилтнуудад зориулсан эрх зүйн гарын авлага гаргана.	-	- Шинэчилж батлагдсан журмууд - Хэвлэгдсэн гарын авлага	2022 онд дотоод журам шинэчлэгдсэн.	Журам шинэчлэгдэн батлагдаж, гарын авлага хэвлэгдсэн байна.	Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг шинэчлэн боловсруулж, нийт ажилтнуудаас санал авч хэлэлцүүлэх шатандаа ажиллаж байна.	50%
5.2	Гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт боловсруулан эмнэлгийн захирлаар батлуулж, ажилтнуудын гүйцэтгэлийг үнэлдэг болно.	-	- Батлагдсан шалгуур үзүүлэлт - Үнэлгээнд хамрагдсан ажилтнуудын тоо	-	Нийт ажилтнуудын 30% нь гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдсан байна.	2025 оны III, IV улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	-
5.3	Хөдөлмөрийн сахилга бат, байгууллагын соёл, ажилтнуудын харилцаа хандлагыг сайжруулах сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах - Монголын зөөлөн ур чадварын нийгэмлэг	Төсөл хөтөл бөр	- Сургалтын тайлан, батлагдсан хөтөлбөр, удирдамж - Хамрагдсан ажилтнуудын тоо	-	Нийт ажилтнуудын 80-90 хувийг сургалтад бүрэн хамруулсан байна.	Удирдлага, манлайлал, харилцаа хандлага, ёс зүй, хөдөлмөрийн сахилга батыг сайжруулах чиглэлд	100%

	- Монголын Бурханы Шашинтны Төвийн “Лэгмон төв” - Удирдлагын академи - Хувь хүний хөгжлийн институт - Холбогдох төрийн байгууллагуудтай хамтарсан эрх зүйн сургалт					нийт ажилтнуудыг хамруулсан 17 удаагийн сургалтыг амжилттай зохион байгуулсан. <i>Дэлгэрэнгүйг хавсралт тайланд тусгасан</i>	
5.4	Шаардлагатай албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж эмнэлгийн захирлаар батлуулна.	-	Батлагдсан албан тушаалын тодорхойлолт	Бүрэн шинэчлэгдэж байгаагүй	50 албан тушаалын тодорхойлолт шинэчлэгдсэн байна.	УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2024.11.25-ны өдрийн А/371 тушаалаар “Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах” ажлын хэсгийг 24 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар ажлын хэсэг нь нийт 10 нэгжийн 62 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан	70%

5.5	Эмнэлгийн ажилтнуудад хууль эрх зүйн мэдлэг олгох видео хичээлийн цахим сан үүсгэн гадаад дотоод цахим хуудсанд байршуулна.	-	-Үүсгэсэн видео хичээлийн сан -Цахим санд хандсан ажилтнуудын тоо	Анх удаа хийгдэнэ	Хэрэглэхэд хялбар эрх зүйн цахим сан үүсэж, хэрэглээнд нэвтэрсэн байна.	“УНТЭ-ийн Хөдөлмөрийн дотоод хэм, хэмжээ сэдэвт 23 минутын цахим видео хичээлийг хийж, видео хичээлийг “Шинэ ажилтны чиглүүлэх, дасан зохицох хөтөлбөр” –ийн сургалтад ашиглаж байна.	100%
5.6	Шинэ ажилтныг чиглүүлэх, дасан зохицох хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана.	-	-Батлагдсан хөтөлбөр -Хөтөлбөрт хамрагдсан шинэ ажилтнуудын тоо	Шинэ сувилагч нарын хөтөлбөр хэрэгждэг	Шинэ ажилтнууд хөтөлбөрт бүрэн хамрагдсан байна.	Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны А/01 тоот тушаалаар “Ажилтан хөгжүүлэх хөтөлбөр”-ийг, 2022 оны А/44 тоот тушаалаар “Шинэ ажилтныг чиглүүлэх, дасан зохицох хөтөлбөр”-ийг тус тус баталж мөрдөн ажиллаж байна. 2025 оны 1-р улиралд шинээр ажилд томилогдсон 15 ажилтан, чөлөөнөөс ажилдаа эргэн томилогдсон 10 ажилтанд 22 сэдэвт хөтөлбөрөөр сургалтыг зохион байгуулсан.	90%
5.7	Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	Жил бүр төлөвлөгөө батлуулан ажилладаг.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	УНТЭ-ийн эрх бүхий албан тушаалтан нь 2025 онд авлигын эсрэг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 чиглэлээр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 52	30%

						ажилтан ХАСХОМ, 6 ажилтан урьдчилсан мэдүүлэг гаргасан.	
ЗОРИЛТ 6: Чанарын менежментийн тогтолцоог нутагшуулах /MNS ISO 9001:2016 стандарт/							
6.1	Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага MNS ISO 9001:2016 стандартын мэдлэг сэргээх сургалтыг зохион байгуулна.	-	- Сургалт зохион байгуулсан тайлан - Хамрагдсан ажилтны тоо	2023 онд эмнэлгийн хэмжээнд сургалт зохион байгуулсан	2-3 удаагийн сургалт эмнэлгийн хэмжээнд зохион байгуулагдсан байна.	2025 оны 05 сарын 20-21-ний өдрүүдэд “Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015” стандартын аудитор бэлтгэх сургалтыг 2 түвшинд зохион байгуулж, нийт 313 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, захиргаа болон дэмжих үйлчилгээний ажилтнуудыг хамруулсан. Сургалтын төгсгөлд мэдлэг сорих шалгалтыг асуумжаар авч үнэлгээ хийсэн.	100%
6.2	Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага MNS ISO 9001:2016 стандартын аудитын сургалт зохион байгуулж шинэ аудиторууд бэлтгэнэ.	-	- Сургалтын тайлан - Бэлтгэгдсэн аудиторовын тоо	2023 онд 32 аудитор бэлтгэгдсэн	10-15 шинэ аудитор сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.	Эмнэлгийн хэмжээнд нийт 90 стандартын аудитор бэлтгэх зорилго тавьж, дадлага ажлыг хуваарийн дагуу зохион байгуулж байна.	70%
6.3	Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага MNS ISO 9001:2016 стандартын аудитад төв, тасаг, албадыг бүрэн хамруулна.	-	- Эмнэлгийн захирлын тушаалаар батлагдсан төлөвлөгөө - Аудит хийсэн тоо	2024 онд 28 төв, тасаг, албад аудитад хамрагдсан.	39 төв, тасаг, албад аудитад бүрэн хамрагдсан байна.	2025 оны эхний хагас жилд ISO 9001:2015 стандартын дотоод аудитад 16 төв, тасаг нэгж хамрагдсан.	90%

			- Үл тохирлын нэгдсэн тайлан				
ЗОРИЛТ 7: Сургалт эрдэм шинжилгээ, судалгаа, гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх							
7.1	“Эрдмийн чуулган - 46” байгууллагын 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулна.	200.0 (үйл ажиллаг ааны орлого)	– Хэвлэгдсэн товхимол – Ажлын тайлан	45 удаа зохион байгуулагдсан	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна	Тус эрдэм шинжилгээний хурлыг 2025 оны IV улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна	30%
7.2	Эмнэлгийн удирдлагын багийг чадавхжуулах гадаад ба дотоодын сургалтыг зохион байгуулна.	Төсөл хөтөл бөр	-Сургалтын тайлан -Хамрагдсан ажилтны тоо	Жил бүр зохион байгуулагддаг	1-2 удаа дотоод нэгдсэн сургалт, 1-2 удаагийн гадаад сургалтад хамрагдсан байна.	2025 оны 3 дугаар сард ЗХНА, ЗАА-дууд хамтран “Удирдах ажилтны зөвлөгөөн 2025” зохион байгуулж нийт 54 эмнэлгийн удирдах албан тушаалтнууд хамрагдсан.	100%
7.3	“Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдал” индекс S(s) 091906 чанарын менежер бэлтгэх, сургалтын хөтөлбөр боловсруулж сургалт эрхлэх зөвшөөрөл авна.	-	– Эрх авсан тушаал шийдвэр – Батлагдсан сургалтын хөтөлбөр	-	Батлагдсан хөтөлбөрийн дагуу 1-2 удаа сургалт зохион байгуулагдсан байна.	ЭМТҮЧАБА нь “Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдал” хөтөлбөрийн хүрээнд төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалт зохион байгуулах гэрээ байгуулж, хөтөлбөрийн дагуу сургалтыг 2025 оны 04 сарын 01-ний өдрөөс зохион байгуулж эхэлсэн. Эхний хагас жилийн байдлаар 2 чанарын менежер бэлтгэгдэж байна.	100%

7.4	“Элэгний эмгэг, урхаг хүндрэлийн менежмент 2025” үндэсний хэмжээний сургалтыг зохион байгуулна.	-	– Тайлан, мэдээ – Оролцсон эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоо	Жил бүр зохион байгуулдаг	Сургалт зохион байгуулагдсан байна.	Тус сургалтыг Гастроэнтерологийн төв 2025.03.17-нд зохион байгуулж нийт 145 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд оролцсон.	100%
7.5	Монголын нефрологийн холбоотой хамтран “Бөөр судлалын үндэсний VI дугаар семинар”-ыг зохион байгуулна.	-	– Өдөрлөг, сургалтын тайлан, мэдээ – Оролцсон эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоо	2020-2024 онуудад тасралтгүй зохион байгуулсан.	Сургалт зохион байгуулагдсан байна.	2025 оны 11 дүгээр сард зохион байгуулагдана.	-
7.6	Суралцагч нарын сургалтын орчныг сайжруулж засвар үйлчилгээ хийнэ.	Төсөл хөтөл Бөр	- Зарцуулсан төсөв – Хийсэн ажлын тайлан	Төслүүд хэрэгжиж байсан	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна	Дотоод заслын интерьерийн зураг төсөл дээр ажиллаж байна.	30%
7.7	БНСУ-ын “ASAN” эрүүл мэндийн төвд нойр булчирхай шилжүүлэн суулгах давтан сургалтад эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдээ хамруулна.	Төсөл хөтөл бөр	- Сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо - Сургалтын тайлан	2022, 2023 онуудад хамрагдсан	1-2 удаагийн сургалтад багаараа хамрагдсан байна.	БНСУ-ын “ASAN” эрүүл мэндийн төвд 3 эмч сургалтад хамрагдсан. Дараагийн ээлжийн сургалт III, IV улиралд төлөвлөгдсөн.	70%
7.8	“WBMT symposium work shop” буюу буюу “Дэлхийн үүдэл эс шилжүүлэн суулгах нийгэмлэг”-ийн Олон Улсын хурлыг зохион байгуулах (36 орны	Төсөл хөтөл бөр	Хурлын тайлан, мэдээ, оролцсон зочид төлөөлөгчийн тоо	Анх удаа	Хурал семинарыг зохион байгуулж төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна	Дэлхийн цусны үүдэл эс шилжүүлэн суулгах нийгэмлэгийн /WBMT/ 9 дахь workshop уулзалт, сургалтыг 2025 оны 06 сарын 26-28 хооронд Улаанбаатар хотод “Holiday” зочид буудлын	70%

	зочид төлөөлөгчид оролцоно)					хурлын зааланд зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг хангаж байна.	
ЗОРИЛТ 8: Цахим эрүүл мэндийн тогтолцооны хөгжүүлэлт, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах, телемедицины үйл ажиллагааг өргөжүүлэх							
8.1	Мэдээллийн аюулгүй байдлын аутсорсинг үйлчилгээ авч аюулгүй байдлын болон эрсдэлийн үнэлгээ хийлгэнэ.	20.0 (үйл ажиллаг ааны орлого)	– Батлагдсан гэрээ, – Үнэлгээний тайлан	2022 онд үнэлгээ хийгдсэн.	Мэдээллийн аюулгүй байдлын үнэлгээ хийгдэж, эрсдэлийг бууруулсан байна.	Мэдээлэл технологийн алба нь 2025 оны 05 сарын 05-ны өдрийн 1/702 тоот албан бичгээр зөвлөх үйлчилгээний байгууллагуудаас үнийн санал авч, шаардлага хангасан байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулахаар бэлтгэж байна.	50%
8.2	Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO/IEC 27001:2022 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.	-	– Зөвлөх үйлчилгээний гэрээ, – Ажлын тайлан	2023 онд MNS ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлсэн.	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Мэдээллийн аюулгүй байдлын аутсорсинг үйлчилгээ авах, МАБ-ийн менежментийн тогтолцоо MNS ISO/IEC 27001:2022 стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг ханган, үе шаттайгаар хийх ажлын төлөвлөгөө боловсруулсан.	30%
8.3	Байгууллагын гадаад цахим хуудсыг шинэчилнэ.	-	– Ажил гүйцэтгэх гэрээ - Акт дүгнэлт	2019 онд цахим хуудасны хөгжүүлэлтийн гэрээ дууссан.	Гадаад цахим хуудас бүрэн шинэчлэгдсэн байна.	Байгууллагын вэб хуудсыг шинэчлэх ажлыг Содон Солушн ХХК-аар гүйцэтгүүлж байна.	70%
8.4	Эмнэлгийн үйл ажиллагааны процессыг	-	- Автоматжуулсан процессын тоо	Анх удаа хийгдэнэ.	Сонгогдсон тасаг үйл ажиллагааны	ЭМС-ын 2025 оны 03 сарын 31-ний өдрийн А/102 тоот тушаалыг	30%

	кодлон автоматжуулах ажлыг эхлүүлэх				процессыг бүрэн кодлосон байна	мөрдлөг болгон, ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Тус төсөлд Зүрхний төв болон Гастроэнтерологийн төвүүд сонгогдсон.	
8.5	МУЗГҮАХ 2.32.6 МУХТ 3.3.15 Телемедициний технологийг ашиглан зайн оношилгоог хөгжүүлэх, дүүрэг, орон нутгийн эмнэлгүүдэд газар зүйн байрлал хамаарахгүйгээр тусламж үзүүлж мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.	-	Зайн оношилгоогоор холбогдсон болон мэргэжил арга зүйгээр ханган ажилласан эмнэлгүүдийн тоо	2022 оноос эхлэн зайн оношилгооны төсөл зогссон	Зайн оношилгооны үйл ажиллагаа тогтмолжсон байна.	УХТЭ-ийн дэргэд байрлах Зайн оношилгооны төвд сар бүр УНТЭ-ийн Дүрс оношилгооны төвийн 1 эмч томилогдон ажиллаж, байна.	90%
8.6	МУХТ 3.3.15 Онлайн амбулаторийн тусламж үйлчилгээг өргөжүүлэн үзлэг оношилгооны хүртээмжийг нэмэгдүүлнэ.	-	- Цахим амбулаторийн кабинетын тоо - Үйлчилгээ авсан иргэдийн тоо	Анх удаа хийгдэнэ	3-4 кабинетыг онлайн тусламж үйлчилгээтэй болгосон байна.	“Онлайн эмнэлэг” төслийн хүрээнд Хэрх үе судлал, Бөөр судлал, Урологи, Гастроэнтерологи, Цусны эмгэг судлалын эмч нарын 3776 удаагийн цахим үзлэг хийгдсэн байна.	100%
ЗОРИЛТ 9: Гамшгийн үеийн бэлэн байдлыг ханган ажиллах, шинэ болон сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх							
9.1	МУХТЖҮЧ 2.2.1 Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг шинэ болон сэргэж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үзүүлэх сургуулилалт зохион байгуулна.	-	– Үзүүлэх сургуулилалт хийсэн тайлан – Хамрагдсан ажилтны тоо	Жил бүр зохион байгуулагддаг	Холбогдох төв, тасаг, алба, нэгжүүд үзүүлэх сургуулилтад бүрэн хамрагдсан байна.	III улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн.	-

9.2	Эмнэлгийн төв байрны нийтийн эзэмшлийн талбайд галын утаа мэдрэгч, дохиоллын систем, стикер, галын булан тавьж галын аюулгүй байдлыг хангана.	19.0 (үйл ажиллаг ааны орлого)	– Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь, – Ажлын тайлан	2023 онд галын аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ дотооддоо хийсэн.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	Галын аюулгүй байдлыг хангаж эхний байдлаар 19,5 сая төгрөгийн өртөг бүхий Гал унтраагуур - 90, Гал унтраагуурын суурь - 90, Хяналтын таг - 90, Галын Сарай – 4 иж бүрдэл зэрэг нэн шаардлагатай худалдан авалтыг хийж, төв, тасаг, нэгжүүдэд тараан байршуулсан. Галын утаа мэдрэгч, дохиоллын систем худалдан авах тендер шалгаруулалтын бэлтгэл ажил хангагдаж байна.	90%
9.3	Галын аюулгүй байдлын сургалтыг Сүхбаатар дүүргийн ОБЕГ-тай хамтран хийнэ.	-	– Сургалтын тайлан, удирдамж, – Хамрагдсан ажилтны тоо	2022 онд дотоодын сургалтыг төв тасаг нэгжид хийгдсэн.	Сургалт зохион байгуулагдсан байна	Сүхбаатар дүүргийн ОБЕГ-тай хамтран эмнэлгийн нийт ажилтнуудад галын аюулгүй байдлын сургалтыг хийхээр төлөвлөсөн.	30%
9.4	Эмнэлгийн 4 нөөц үүсгүүрийн бэлэн байдлыг ханган ажиллана.	12.0 (үйл ажиллаг ааны орлого)	- Бэлэн байдлыг хангасан нөөц үүсгүүрийн тоо - Гэрээ дүгнэсэн акт	Засвар үйлчилгээний гэрээ 2024 онд хийгдсэн.	2025 оны гэрээ байгуулагдаж төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	“Монхорус интернэшнл” ХХК-тай “Дизель-генератор”-ын үзлэг үйлчилгээний гэрээг байгуулан, улирал тутамд үзлэг үйлчилгээг хийж бэлэн байдлыг ханган ажиллаж байна.	100%
9.5	Эмнэлгийн аянга зайлуулагч, газардуулгын болон цахилгаан энергийн хэмжилт хийлгэнэ.	30.0 (үйл ажиллаг ааны орлого)	- Газардуулгын протокол, дүгнэлт	2023 онд хийгдсэн.	Хэмжилтийн протокол гарч арга	Эмнэлгийн аянга зайлуулагч, газардуулгын болон цахилгаан энергийн хэмжилт 2025 оны 05 сард	100%

		ааны орлого)	- Хийсэн ажлын тайлан		хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	хийлгэсэн. Протокол, дүгнэлт 06 дугаар сард гарна.	
9.6	Цацрагийн гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн батлуулж хэрэгжилтийг ханган ажиллана.	-	- Шинэчилсэн төлөвлөгөө - Хэрэгжилтийн тайлан	2021 онд батлагдсан	Эрх бүхий байгууллагаар хянуулж батлуулсан төлөвлөгөө, тухайн жилийн хэрэгжилтийн тайлан	III улиралд хийхээр төлөвлөсөн.	-
ЗОРИЛТ 10: Үндэсний хэмжээнд болон эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах							
10.1	МУЗГҮАХ 2.3.1.2 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.	-	- Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2024 онд батлагдсан.	Төлөвлөсөн арга хэмжээнүүд бүрэн хэрэгжсэн байна.	Эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт сурталчилгаа хийн, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. <i>Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт тайлангаас харна уу.</i>	90%
10.2	Дэлхийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлнэ.	-	- Хийсэн ажлын тайлан - Оролцсон үйлчлүүлэгчийн тоо	Жил бүр тэмдэглэдэг	Нийт 28 өдрийг тэмдэглэн өнгөрүүлсэн байна.	2025 оны эхний 5 сарын байдлаар Дэлхийн эрүүл мэндийн 9 тэмдэглэлт өдрийн өдөрлөг зохион байгуулсан.	90%
10.3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрүүл мэндийн байгууллагаар саадгүй үйлчлүүлэх, мэдээлэл авах боломжоор хангах ажлын хүрээнд ажилтнуудын дунд дохионы хэлний сургалтыг зохион байгуулна.	1.0 (үйл ажиллаг ааны орлого)	- Сургалтын тайлан - Бэлтгэгдсэн ажилтны тоо	2020 онд зохион байгуулагдсан .	Тасаг нэгж бүрээс 1 ажилтан сургалтад хамрагдаж бэлтгэгдсэн байна.	“Сонсголгүй иргэдийн үндэсний холбоо”-той хамтран “Харилцааны анхан шатны дохионы хэл” 2025.05.26-ний өдрөөс 3 удаагийн 12 багц цагийн сургалт зохион байгуулсан. Нийт 29 эмч, эмнэлгийн	100%

						мэргэжилтнүүдийг хамруулсан	
10.4	Хүн амд зонхилон тохиолдох өвчин эмгэгээс сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох контент, подкаст бэлтгэж ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг тасралтгүй зохион байгуулна.	1.0 (үйл ажиллаг ааны орлого)	- Бүтээгдсэн контентийн тоо - Иргэдэд хандалт болон үзэлтийн тоо	2020 онд хийгдэж байсан.	Нийт 10-15 төрлийн контент эмнэлгийн цахим хуудас, фейсбүүк хуудсанд байршуулсан байна.	УНТЭ-ийн Захирлын ажлын алба, Нийгмийн эрүүл мэндийн албадууд болон нийт эмнэлзүйн төв, тасгууд хамтран ард иргэдийн Эрүүл мэндийн боловсролыг сайжруулах, нийгмийн эрүүл мэндийн зөвлөгөө контент 12-ыг бэлтгэж, УНТЭ-ийн фейсбүүк пэйж хуудсаар дамжуулан 50 мянга гаруй хүнд хүрсэн хандалттай байна.	100%
10.5	“Эмийн аюулгүй байдлын 7 хоног” арга хэмжээг зохион байгуулна.	-	- Удирдамж - Хөтөлбөр - Арга хэмжээний тайлан	Жил бүр зохион байгуулдаг	Арга хэмжээг амжилттай зохион байгуулсан байна.	IV улиралд хийхээр төлөвлөсөн.	-
10.6	“Бичил биетний тэсвэржилтийн дэлхийн 7 хоног” арга хэмжээг зохион байгуулна.	-	- Удирдамж - Хөтөлбөр - Арга хэмжээний тайлан	Жил бүр зохион байгуулдаг	Арга хэмжээг амжилттай зохион байгуулсан байна.	IV улиралд хийхээр төлөвлөсөн.	-
ЗОРИЛТ 11: Эмнэлгийн түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх болон хөрөнгө оруулалтын чиглэлээр							
11.1	Эмнэлэг үүсгэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлнэ.		– Батлагдсан төлөвлөгөө – Хэрэгжилтийн тайлан	2015 онд түүхт 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна	УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2024.11.05-ны өдрийн А/347 тоот “УНТЭ-ийн түүхт 100 жилийн ойн арга хэмжээ, бэлтгэл ажлыг зохион байгуулах тухай” батлагдсан тушаалын дагуу ажлын хэсгүүд бэлтгэл ханган ажиллаж байна.	70%


11.2	Засгийн газрын дэмжлэгтэй нийлүүлэгдэх эм савлалтын автомат машиныг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.	1,000 (улсын төсөв)	Хүлээн авсан автомат машин Гэрээ, акт дүгнэлт	Эм савлалтыг гараар савлаж байна.	Автомат савлалтын машиныг суурилуулсан байна.	2025.05.28-нд Эмийн автомат савлалтын машин бүхий агуулахын нэгдсэн систем тендер зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан Доктор Тун ХХК нь ЭМЯ-тай гэрээ байгуулах шатанд ажиллаж байна. Тус байгууллагатай мэдээлэл солилцон, эмийн ухаалаг програм, эмийн харилцан нөлөөлөл, эмнэлэгт хэрэглэж буй бүх эмийн дэлгэрэнгүй судалгааг хийх, үйл ажиллагааны журам болон бусад бэлтгэл ажлууд хийгдэж байна.	50%
11.3	1971 онд ашиглалтад орсон эмнэлгийн төв барилгын гадна фасадыг шинэчилнэ.	3,400 (улсын төсөв)	Шинэчилсэн фасадыг хүлээн авсан акт, дүгнэлт	Төв байр нь 1971 онд ашиглалтад орсон.	Эмнэлгийн төв барилгын гадна фасадны ажил бүрэн хийгдсэн байна.	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн барилгын гадна фасадын засварын ажлын тендерийг 2024 онд зарлаж, гүйцэтгэгчээр “Би Рич Трейд” ХХК шалгарч засварын ажлын гэрээг байгуулсан. 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс тус засварын ажил эхэлсэн бөгөөд 2025 оны 06 дугаар сард дуусгах төлөвлөгөөтэй явагдаж байна.	70%

11.4	Амбулаторийн хэсгийн хэрэгцээний цэвэр, бохирын усны шугамын засварыг хийнэ.	1,600 (улсын төсөв)	Ашиглалтад оруулсан акт, дүгнэлт	1971 оноос хойш засвар хийгдээгүй.	Цэвэр бохирын шугамын засварын ажил бүрэн хийгдсэн байна.	Тус засварыг “Түмт мөрөн” ХХК 2025.03.15-ны өдрөөс эхлэн хэсэгчлэн эхлүүлсэн. Эхний хэсгийн засварын ажил дуусаж байна.	70%
11.5	Шинээр баригдаж буй хүчилтөрөгчийн үйлдвэрийг хүлээж авч ашиглалтад оруулна.	-	Ашиглалтад оруулсан акт, дүгнэлт	2023 онд НҮБ-ийн Хүүхдийн сангийн санхүүжилт	Хүчилтөрөгчийн үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулсан байна.	III дугаар улиралд хийхээр төлөвлөсөн.	-
11.6	МУХТ 3.3.11 “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв”-ийн барилга болон “Авто зогсоолын барилга”-ын ажлыг үргэлжлүүлнэ.	139,000 тэрбум (улсын төсвийн хөрөнгө)	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	2015 онд эмнэлгийн зүүн байр ашиглалтад орсон	“Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв”-ийн барилгын гүйцэтгэл 20%-тай байна. Авто зогсоолын барилга бүрэн ашиглалтад орсон байна	“Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв”-ийн барилгын суурийн цутгалтын ажил хийгдсэн. Авто зогсоолын барилгын үндсэн цутгалтын ажил дууссан, гадна инженерийн шугамын ажил хийгдэхэд бэлэн болсон.	70%
11.7	Төвийн вен, артерийн судсанд гуурс байрлуулах, мэдрэлийн хориг хийж өвдөлт намдаах зэрэг ажилбарын үед хэрэглэгдэх хүчин чадал сайтай сүүлийн загварын ЭХО аппарат авна.	200.0 (төсөл хөтөл бөр)	– Бичсэн төсөл – Санхүүгийн тайлан	2 эхо аппараттай	Нэмэлтээр орчин үеийн өндөр хүчин чадалтай 1 эхо аппараттай болсон байна.	Хүчин чадал сайтай ЭХО аппаратын хэрэгцээг үндэслэж, төсөл бичсэн. Зохих газрууд руу хүсэлт явуулсан.	30%
11.8	Амбулаторийн 1 давхарын лавлагаа, цахим бүртгэлийн хэсэгт орчин үеийн шийдэл бүхий иж бүрэн засвар хийнэ.	400.0 (хөрөнгө оруулалт)	– Засварын тайлан	2019 онд засвар хийсэн	Лавлагаа, цахим бүртгэлийн хэсэгт бүрэн засвар хийгдсэн байна.	Амбулаторийн 1 давхарт цахим бүртгэлийн хэсэг, амбулаторийн эмийн сан, эмийн сангийн агуулах, үйлчлүүлэгчийн өлгүүрийн	90%

						хэсэг зэрэг нийт 542м ² талбайг 400.0 гаруй сая төгрөгийн өртгөөр орчин үеийн дэвшилтэт технологиор засаж тохижуулж байна.	
--	--	--	--	--	--	--	--

Төлөөлөгөө тайлагнасан:

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
(албан тушаал)



Төсвийн шууд захирагч


..... /Л.БЯМБАСҮРЭН/
(гарын үсэг)

.....
(огноо)

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Гүйцэтгэлийг дэлгэрэнгүйгээр харуулбал:


д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Хэрэгжилтийн тайлан /2025 оны эхний хагас жилийн байдлаар/	Гүйцэтгэл-ийн хувь
Зорилго: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, төвлөрлийг сааруулах, хүний нөөцийг чадавхжуулан байгууллагын соёлыг төлөвшүүлэх, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх			
Зорилт 1: Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх			
1.1	ЗГҮАХ 2.3.4.1 Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалтад орсон меньерийн өвчний хүнд хэлбэрийн үеийн мэс заслыг нэвтрүүлэх хүний нөөцийг сургаж бэлтгэнэ.	УНТЭ-ийн ЧХХСМЗТ-ийн эмч Н.Ган-эрдэнэ 2024 онд Англи Улсын “Leeds teaching hospital”-д 6 сар Чих болон гавал тархины мэс заслын чиглэлээр, эмч Д.Уянга Малайз Улсын Малай их сургуулийн эмнэлэгт 2 сарын хугацаатай Меньерийн өвчний хүнд хэлбэрийн үеийн мэс заслын эмчилгээний чиглэлээр суралцсан. Эмч З.Мэндсайхан Малайз Улсын Малай их сургуулийн эмнэлэгт 3 сарын хугацаатай Чихний эмгэгийн мэс заслын чиглэлээр өөрийн зардлаар суралцаж байна. Монгол Улсад 2023 оны байдлаар Меньерийн өвчний 1244 тохиолдол оношлогдсон, хянагдаж байна. Тэдний 2 нь гадаад оронд мэс засал хийлгэсэн ба 1 хүний эмчилгээний нийт зардал 19.000 доллар болсон. Меньерийн эмгэгийг оношлох, эмчлэхийн тулд УНТЭ-т тэнцвэрийн лаборатори байгуулах шаардлагатай байна. Иймээс тэнцвэрийн лаборатори байгуулах төсөл бичиж, ЭМЯ-д танилцуулсан. УНТЭ-ийн эмч нарын баг Малайз Улсын Малай их сургуулийн эмнэлгийн профессор, АУ-ны доктор Н.Препагерантай хамтран Меньерийн өвчний 2 тохиолдолд мэс засал эмчилгээ амжилттай хийсэн. 	90%
Зураг 1. ЧХХСМЗТ-ийн эмч нар суралцсан байдал			

1.5	Хоол боловсруулах замын дурангийн сургалтын төв байгуулах төслийг эхлүүлж бэлтгэл ажлыг хангана.	УНТЭ-ийн ГЭТ-ийн эмч нар Хоол боловсруулах замын дурангийн сургалтын төв байгуулах төслийн баримтыг Англи, Монгол хэл дээр бэлтгэж 4 байгууллагад цахимаар хүргүүлсэн. Мөн тус төслийн баримт бичгийг ЭМЯ-ны төвлөрлийг сааруулах хөтөлбөрийн төсөлд хүргүүлэхээр бэлдэж байна.	30%
1.6	Сүхбаатар дүүргийн “Сэлбэ” нэгдсэн эмнэлгийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах, салбар эмнэлгийн хэмжээнд хөгжүүлнэ.	УНТЭ-ийн удирдлагын баг нь Сүхбаатар дүүргийн Сэлбэ нэгдсэн эмнэлэгтэй 2025.04.16-нд УНТЭ 39/25 дугаартай хамтын ажиллагааны санамж бичиг зурсан. Тус гэрээний дагуу эхний суралцах эмч, сувилагч нарын нэрс ирсэн бөгөөд сургах бэлтгэл бүрэн хангагдсан. 	50%
1.7	Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлгийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.	Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлгийг мэргэжил арга зүйгээр хангах хамтын ажиллагааны гэрээ хийх ажил хэлцлийн шатанд байна. Хамтран ажиллах гэрээний хүрээнд 5 чиглэлээр Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлгийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.	30%
Зорилт 2: Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах			
2.1	ДОТ-ийн Цөмийн онош зүйн хэсэгт Олон улсын атомын энергийн газрын дэмжлэгтэй Спект СТ аппаратыг хүлээн авч суурилуулан ашиглалтад оруулна.	Олон улсын атомын энергийн газрын дэмжлэгтэй хэрэгжиж буй МОН/6023 төслийн хүрээнд УНТЭ-т суурилагдах Спект СТ аппарат нь 2025.05.21-ны өдөр эмнэлэгт ирсэн. 2025.06.11-ний өдөр Унгар улсаас суурилуулалтын инженер хүрэлцэн ирж суурилуулалтын ажил эхэлсэн.	70%
2.2	Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагааг сайжруулна.	Эмнэлгийн гадна болон дотно засвар үйлчилгээ эхлүүлсэнтэй холбоотой Захиргааны 42 ажилтан ерөнхий захирлын “Эмнэлгийн захиргааны хариуцлагатай жижүүрийн хуваарь удирдамж батлах тухай” 2025.05.14-ний өдрийн А/144 тушаалаар батлагдсан хуваарийн дагуу захиргааны ажилтнууд жижүүрийн үйл ажиллагаа явуулж, нийт 121 эрсдэлийг урьдчилан тооцож мэдээлэн, хариу арга хэмжээ авч ажилласан “Удирдах ажилтны манлайлал”-ын аяныг зохион байгуулах, ажлын төлөвлөгөөг батлах тухай” ерөнхий захирлын 2025.05.14-ний өдрийн А/143 тушаалаар 11 арга хэмжээ бүхий төлөвлөгөө баталж, нийт удирдах ажилтнуудын хариуцлагыг дээшлүүлэн, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Нийт тасаг, төвийн чанарын багийн гишүүдийг ерөнхий захирлын 2025.05.19-ны	90%

		өдрийн А/150 тушаалаар шинэчлэн батлуулж, чанарын багийн гишүүдийг 80 болгон өргөжүүлж, эрсдэлийн бүртгэл хийх үйл ажиллагааг тогтмолжуулсан. Тусламж үйлчилгээний чанар, хууль тогтоомж, эрсдэлийн удирдлагын чиглэлээр нийт 5 удаагийн сургалт зохион байгуулсан. ЭМТҮЧАБА-аас үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор: 1. “Хэцүү үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээ” 2. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ” 3. “Мэс заслын тусламж үйлчилгээний журам”-ыг шинээр боловсруулан батлуулж нийт эмч, сувилагч эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэдээлсэн. Мөн мэс заслын 7 тасаг төвүүдийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна. Амбулаторид үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор: ➤ Үйлчлүүлэгчийн эрх зөрчигдөх, аливаа эрсдэл учрахаас сэргийлэн үйлчлүүлэгчийн эрх үүргийг монгол, англи хэлээр бэлтгэсэн. ➤ Амбулаторийн цахим бүртгэлийн хэсэгт ухаалаг хөтөч дэлгэц 2 ширхгийг байрлуулсан. ➤ Амбулаторийн нийт 32 кабинетуудын хаяг, байршил заасан дуугүй хөтчүүдийг шинэчилсэн. ➤ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 17 тэргэнцрийг засаж сайжруулсан. ➤ Амбулаторийн үйлчлүүлэгчдэд зориулан 1-4 давхрын хүлээлгийн танхимд цаг үетэй холбоотой мэдээ мэдээллийг 3 дэлгэц, 20 ширхэг хөлтэй баннер байрлуулж, 100 үйлчлүүлэгчид гарын авлага тараасан. ➤ Амбулаторийн орох хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан налуу замыг стандартад нийцүүлэн засаж, 2м ханын бариул шинээр хийсэн. ➤ Өндөр настан, жирэмсэн эх, хөдөлмөрийн чадвараа 70% алдсан хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдэд дараалал харгалзахгүй цаг олгох үйлчилгээг тусгай №1 цонхоор үйлчилдэг болж, хэвшүүлсэн. ЭМТҮЧАБА, Сувилахуйн алба хамтран нийт 14 тасаг, төвд эрсдэлийн үнэлгээг хийж, тусламж үйлчилгээг сайжруулах эрсдэлийг бууруулах “Хамтдаа хэвшүүлье” сарын аяныг зохион байгуулсан. 2025 оны эхний хагас жилд УНТЭ-д иргэд үйлчлүүлэгчдээс 85 өргөдөл гомдол ирснээс 34 (40%) мэс заслын анагаах ухааны салбартай хамааралтай, 18 (52%) эмч мэргэжилтнүүдийн ёс зүй харилцаа хандлагатай хамааралтай, 12(35%) үзлэг болон шинжилгээтэй хамааралтай, 6(17%) хэцүү үйлчлүүлэгчтэй холбоотой байсан ба тэдгээрт дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээ авч ажилласан.	
2.3	Амбулаториор хийгддэг мэс ажилбар, үйлдлийн явцад мэдээгүйжүүлэг, ажилбарын үеийн тайвшруулалт хийх үйл ажиллагааны журам батлуулж мөрдөн ажиллана.	ЭМТҮЧАБА, МХНТ хамтран “Амбулаториор хийгддэг мэс ажилбар, үйлдлийн явцад мэдээгүйжүүлэг, ажилбарын үеийн тайвшруулалт хийх үйл ажиллагааны журам” боловсруулсан. Тус журам нь 11 бүлэг 2 хавсралтаас бүрдсэн бөгөөд хэлэлцүүлгийн шатанд байна.	50%


2.4	Харилцааны бэрхшээлтэй буюу аман харилцаа үүсгэх боломжгүй үйлчлүүлэгчийг таних аргыг нэвтрүүлж, холбогдох журмын хэрэгжилтийг ханган ажиллана.	“Сонсголгүй иргэдийн үндэсний холбоо”, УНТЭ-ийн НЭМА, СЗУЭТ-ууд хамтран 2025.05.26-ний өдрөөс “Харилцааны анхан шатны дохионы хэл” 3 удаагийн 12 багц цагийн сургалтыг зохион байгуулж, нийт 29 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан.  Зураг 4. Дохионы хэлний сургалт	100%
2.5	Өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эмийн аюулгүй байдлыг хангах, хяналтыг сайжруулах, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.	Эмзүйн албанаас эмнэлгийн хэмжээнд хэрэглэгдэж буй 1. Сонгодог өндөр эрсдэлт эм, 2. Ижил дуудагддаг өндөр эрсдэлт эм, 3. Ижил харагддаг өндөр эрсдэлт эмийн мэдээллээр таниулах зурагт хуудас бэлтгэн цахимаар болон нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний яриан дээр мэдээллийг хүргэн ажиллаж байна. Мөн ижил савлагаатай, адил харагддаг эмэнд анхааруулах тэмдэг наан хяналт тавин ажиллаж байна.  Зураг 5. Зурагт санамж хуудас  Зураг 6. Анхааруулах тэмдэг наасан байдал	90%
2.6	ОЭТН-ийн халдварыг бууруулах, тандалт хяналтыг сайжруулах, урьдчилан	Эрүүл мэндийн сайдын А/538, А/539 тушаалд үндэслэн ЭТҮХХ-ыг мэдээлэх алгоритмын дагуу хэвтэн эмчлүүлэгчдийн өвчний түүхэнд тандалтыг хийж, сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед ХСХА шуурхай арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.	90%

	сэргийлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ.	ОЭТН-н ЭТҮХХ-н тандалт судалгааны ажлын хүрээнд 2025 оны эхний хагас жилд Олон эмэнд тэсвэртэй нянгийн нийт 453 тохиолдлыг ЭЭНСЛ-с шуурхай мэдээлэх тогтолцооны дагуу ХСХА-нд мэдээлсэн. Үүнд: ➤ Амбулаторид-162 ➤ Яаралтай тусламжийн тасагт-32 ➤ Дотрын тасагт-108, мэс заслын тасагт-151 буюу хэвтэн эмчлүүлэх тасагт нийт 259 тохиолдол илэрсэн. 259 тохиолдлоос ЭТҮХХ-ын сэжигтэй олон эмэнд тэсвэртэй нянгийн 25 тохиолдолд тандалт судалгааг хийсэн. Бүртгэгдсэн тохиолдол бүрд эрсдэлийн түвшнийг тооцон, тохирох хариу арга хэмжээг авч, ХСХА-аас аргазүйн зөвлөгөөг тогтмол өгч ажилласан.	
2.7	Үйлчлүүлэгчийг дэмжих алба байгуулна.	“УНТЭ-ийн дүрмийг шинэчлэн батлуулах хүсэлт болон дүрмийн шинэчилсэн төсөл”-ийг 2025 оны 06 дугаар сард ЭМЯ-нд хүргүүлсэн бөгөөд шинэчлэгдсэн дүрмийн дагуу батлагдах бүтцэд “Үйлчлүүлэгчийг дэмжих алба”-ыг байгуулан ажиллахаар төлөвлөсөн.	30%
2.8	“Сувилагчийн нэг өдөр” аян өдөрлөгийг зохион байгуулна.	“Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн 100 жилийн ой” болон “Олон улсын сувилагчдын өдөр”-ийг тохиолдуулан сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулсан Reel бичлэгийн уралдаан 2025.05.05-ны өдрөөс 05 сарын 12-ны өдрийн хооронд амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү уралдаанд эмнэлгийн нийт 20 тасаг, төвийн сувилахуйн багууд оролцсон бөгөөд бичлэгүүдийг удирдамжийн дагуу хүлээн авч, дотоод фейсбүүк группт нийтэлсэн. Шалгаруулалтыг удирдамжийн дагуу хоёр үндсэн шалгуураар хийсэн бөгөөд бичлэг бүрийн like болон реакшин тоог 50 хувь, удирдлагын багийн зүгээс бүтээлч, сэдэвтэйгээ нийцсэн байдал, гүйцэтгэлийг үнэлсэн оноог 50 хувь болгон тооцож, нийлбэр оноогоор эцсийн дүнг гаргасан. Шалгаруулалтын дүнд Эрүүл мэндийг дэмжих төвийн сувилахуйн баг нэгдүгээр байрт, Уушги харшил судлалын төвийн баг хоёрдугаар байрт, Амбулаторийн баг гуравдугаар байрт тус тус шалгарсан бол Нүд судлал, мэс заслын тасгийн хамт олон тусгай байрын шагнал хүртлээ.	100%



Зураг 8. Reel видео бичлэгийн уралдааны удирдамж, Reel бичлэгийн хэсгүүд

- ОУ-ын сувилагчдын өдрийг тохиолдуулан mass.mn, arslan.mn мэдээллийн сайтуудад дараах сувилагч, тусгай мэргэжилтнүүд мэдээ өгч ажилласан.
- Дүрс оношилгооны төвийн сувилагч А.Молом
 - Яаралтай тусламжийн тасгийн сувилагч Ц.Уянга
 - СЭЗТ, Уламжлалт эмчилгээний тасгийн сувилагч Л.Болормаа
 - Яаралтай тусламжийн тасгийн ахлах сувилагч Т.Баянсүрэн
 - Эрчимт эмчилгээний тасгийн ахлах сувилагч Х.Ганчимэг
 - Сувилахуйн албаны арга зүйч Б.Цэгмид - ТВ-5 телевизийн Гэгээн эрүүл мэнд подкаст

			
Зураг 9. ОУ-ын сувилагчдын өдрийг тохиолдуулан мэдээллийн сайтад өгсөн мэдээлэл			
Зорилт 3: Санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, нөөцийн удирдлагыг сайжруулах			
3.1	Эмнэлгийн e-Health, VERITECH ERP санхүүгийн системүүдийг өгөгдөл солилцдог болгож улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн хөгжүүлэлтийг программд хийнэ.	Эрүүл мэндийн сайдын 2025.05.07-ний өдрийн А/190 тоот тушаалаар Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, хэрэглэгчийн сэтгэл ханамж, санхүү нөөц бүртгэлийн системийн процессыг оновчтой, үр ашигтайгаар зохион байгуулах, нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, цахимжуулалтыг эрчимжүүлэх зорилгоор санхүүжилтийг шийдвэрлэсэн. Агуулахын бүртгэлийн систем шинээр худалдан авч, программын хөгжүүлэлт хийж буйтай холбоотой техникийн тодорхойлолтыг боловсруулж, худалдан авалтыг зохион байгуулж байна. Эмийн орлого зарлага нь оношоор болон өвчтөнөөр тайлан гардаг болох бөгөөд эм, эмнэлгийн хэрэгсэл баркодын системд бүрэн нэвтэрнэ..	70%
3.2	ЭМДЕГ-тай байгуулсан тусламж үйлчилгээ худалдах, худалдан авах гэрээнд үндэслэн эмнэлзүйн төв, тасгуудын орлого зарлагыг тооцож, нотолгоонд суурилсан төлөвлөлт хийн ажиллана.	Эмнэлгийн Ерөнхий захирлаар удирдуулан бүх тасаг нэгжийн эрхлэгч, дарга нартай нийт 4 удаагийн уулзалт зохион байгуулж, ЭМДЕГ-тай байгуулсан гэрээнд үндэслэн төлөвлөлтийг хийж, танилцуулсан. 	50%


Зураг 10. Уулзалт

4.2	Донорын элгийг дурангаар тайрах мэс заслын технологийг нэвтрүүлнэ.	2025.02.22-ны өдөр Элэг шилжүүлэн суулгах мэс заслын донорын мэс заслыг хэвлийн дурангийн аргаар УНТЭ-д анх удаа УНТЭ-ЭШСБаг, БНСУ-ын Асан эрүүл мэндийн хамт олонтой хамтран амжилттай хийсэн.	100%
4.3	Нүдний даралт ихсэх өвчний үед хийгддэг MIGS мэс заслыг нэвтрүүлж, нутагшуулна.	Австралийн Sight For All сангийн глаукомын эмч нартай хамтран нүдний даралт ихсэх өвчний үед хийгддэг бичил хүрцэт /MIGS/ мэс заслыг нэвтрүүлж нутагшуулахаар ажиллаж байна. Тус сангийн зочин профессор ирж, 2025 оны 06 сарын 10-ны өдөр Нүдний даралт ихсэх өвчний 1 тохиолдолд MIGS мэс заслыг хийж байна.	90%
4.4	Хоол боловсруулах замын дурангийн эмчилгээний шинэ аргыг тусламж үйлчилгээнд нэвтрүүлнэ. - Дурангаар ходоодны хавдрыг бүх давхаргаар бүтнээр нь хуулах (EFTR)	Шаардлагатай эмнэлгийн хэрэгслийг захиалгад оруулсан.	30%
4.5	Төвөнх, залгиур, толгой хүзүүний лазерын эмчилгээг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлнэ.	ЧХХСМЗТ-ийн эмч С.Нэргүй 2017 онд Франц, 2018 онд БНЭУ-д дууны мэс засал, лазер мэс заслын гардан сургалтад хамрагдсан. Эмч М.Лутзул БНСУ-ын Донг-А их сургуулийн эмнэлэгт толгой хүзүүний хавдрын мэс заслаар 1 сарын дадлагажих сургалтыг дүүргэсэн ба ХСҮТ-ийн ТХМЗТ-т чих хамар хоолойн хавдрын чиглэлээр 1 жилийн дээшлүүлэх сургалтад сурч байна. Эмч Д.Нямсүрэн Тайвань Улсын Цэргийн эмнэлэгт толгой хүзүүний хавдар, мэс заслын чиглэлээр суралцаж байна. Лазер эмчилгээний төсөл бичиж, зохих газруудад хүргүүлсэн.	30%
4.6	Толгой, хүзүүний хорт хавдрын дурангийн мэс заслыг эхлүүлнэ.	Төвөнх залгиурын баг 2 тохиолдолд дурангийн аргаар хавдрын мэс засал эмчилгээ амжилттай хийсэн. Хавдрын зөвлөх, хүний гавьяат эмч Г.Пүрэвдоржтой хамтран төвөнхийн хорт хавдрын төвөнх бүтэн авах мэс засал-1, хавдрын дараах нөхөн сэргээх мэс засал-1 хийсэн. 2 эмч бэлтгэгдсэн.	90%
4.7	Хорт хавдартай өвчтөнүүдийн ясны үсэрхийллийн өвдөлт намдаах эмчилгээг шинээр нэвтрүүлнэ.	Тус эмчилгээнд хэрэглэгдэх химийн холбогч бодис болон цацраг идэвхт изотопын үнийн судалгааг хийж, төсөвт тусгуулах саналаа эмнэлгийн даргад танилцуулсан. Хүний нөөцийн сургалт 8-р сараас эхлэхээр төлөвлөгдсөн байна.	30%
4.8	Үгийн аудиометрийн шинжилгээг оношилгоонд нэвтрүүлж үндэсний хэмжээнд хөгжүүлнэ.	Үгийн аудиометрийн шинжилгээний стандарт боловсруулсан. Тус стандартыг УНТЭ-ийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, ЭМЯ-нд хүргүүлсэн. Стандарт хэмжилзүйн газрын цахим хуудаст байршуулан санал авч байна. https://estandard.gov.mn/website/news.aspx?id=144	70%
4.9	Гуурсан хоолойн уян дурангаар захын байрлалтай үүсгэврээс эдийн шинжилгээ авна.	Япон улсын NCGM эмнэлэгтэй хамтран төсөл хэрэгжүүлж, 5 эмч, 1 сувилагч бэлтгэн Гуурсан хоолойн уян дурангаар захын байрлалтай үүсгэврээс эдийн шинжилгээ авах технологийг 2025 оны 02 сард шинээр нэвтрүүлж, 5 тохиолдлыг амжилттай хийсэн.	100%

		 Зураг 13. Шинжилгээ авах үе	
4.10	МУХТ 3.3.16 ICT TENS буюу өвдөлт намдаах зорилгоор ашигладаг цахилгаан эмчилгээний аппаратыг сэргээн засах эмчилгээнд нэвтрүүлнэ.	Сэргээн засах эмчилгээний тасгаас цахилгаан эмчилгээний аппаратын хэрэгцээ шаардлагын судалгааг хийж, эмнэлгийн удирдлагад танилцуулсан.	30%
4.11	Ходоод, бүдүүн шулуун гэдэс, хөх, өндгөвч болон бусад хавдрын оношилгоонд шаардлагатай 113 гений мутаци тодорхойлох шинжилгээг бүрэн нутагшуулна.	2025 оны III, IV улиралд тус шинжилгээг хийхээр төлөвлөж байна.	-
4.12	Үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээг хийхэд шаардлагатай HLA typing 11 локуст тодорхойлох шинжилгээг NGS технологи iSeq 100 төхөөрөмж дээр хийж гүйцэтгэнэ.	2024 онд HLA typing 11 локуст тодорхойлох шинжилгээг 15 тохиолдолд хийсэн. 2025 онд тус эмчилгээг нийт 40 үйлчлүүлэгчид хийхээр төлөвлөсөн. 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 80 үйлчлүүлэгчид хийсэн. Тус шинжилгээ тогтмол хийгдэж байна.	100%
4.13	Мөгөөрсний гэмтлийг үүдэл эс ашиглан эмчлэх технологийг нэвтрүүлнэ.	2025 оны 05 сард БНСУ-н Medrex үүдэл эсийн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээг байгуулсан. Тус хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-н эмч ХҮСҮСТ-ийн эмч нарт сургалт явуулсан. Цаашид ХҮСҮСТ Цусны эмгэг судлал чөмөг шилжүүлэн суулгах төвийн эмч нар хамтран мезенхимийн үүдэл эс ялгах эмчилгээ хийхээр ажиллаж байна.  Зураг 14. Хамтын ажиллагааны гэрээ	30%

4.14	Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын дархлаа эмчилгээг нэвтрүүлж нутагшуулна.	Хавдрын дараах дархлаа эмчилгээг хийх бүрэн тогтолцоо бүрдсэн. БШГМЗТ-ийн 2 хими эмчилгээний эмч сурч бэлтгэгдсэн. Уг эмчилгээнд хэрэглэгдэх дархлааны эмүүдийг 2025 оны эмийн захиалгад оруулсан.	70%
4.15	Гамма пробыг хөх хадгалах, хавдрын хагалгаа болон бамбайн дэргэдэх булчирхайн байршлыг мэс заслын үед ашиглан илрүүлж хагалгаа, эмчилгээний менежментийг сайжруулах технологийг нэвтрүүлнэ.	Бамбайн дэргэдэх булчирхайн гамма проб мэс заслыг ДОТ болон Эрүү нүүрний мэс заслын тасаг хамтран хийдэг. 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 5 мэс ажилбарт хамтран орсон байна.	90%
4.16	Элэгний анхдагч хавдрын тэжээгч судсаар бөглөх эмчилгээнд химийн тариа ялгаруулагч бөмбөлөг материалаар бөглөх эмчилгээг практикт нэвтрүүлнэ.	Deb-TACE буюу элэгний анхдагч хавдрын тэжээгч судсыг химийн тариа ялгаруулагч бөмбөлөг материалаар бөглөх эмчилгээг 2025 оны I улирлаас эхлэн эмнэлзүйд нэвтрүүлж эхэлсэн бөгөөд эхний хагас жилийн байдлаар 3 тохиолдолд drug eluting beads ашиглан TACE эмчилгээг хийсэн байна.	90%
4.17	Элэг шилжүүлэн суулгах эмчилгээний зааврыг шинэчлэн батлуулна.	Элэг шилжүүлэн суулгах эмчилгээний зааврыг шинэчлэн боловсруулж, УНТЭ-ийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн.	70%
4.18	Бөөр шилжүүлэн суулгах эмчилгээний зааврыг шинэчлэн батлуулна.	Бөөр шилжүүлэн суулгах эмчилгээний зааврыг шинэчлэн боловсруулж, УНТЭ-ийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэх шатанд ажиллаж байна.	30%
4.19	Хорт хавдрын дараах бай эмчилгээнүүдийг өөрийн эмнэлэгт бүрэн нутагшуулна - Хэрх үений бай эмчилгээ - Цусны хавдрын бай эмчилгээний 2-3 дугаар эгнээний 1-2 бай эмчилгээ	- EULAR, ACR, APLAR-н болон МУ-д батлагдсан эмчилгээний заавар, удирдамжид орсон Хэрх үе холбогч эд, аутоиммун эмгэгийн үед зайлшгүй шаардлагатай bDmard's эм бэлдмэлүүдийг нэвтрүүлэх төслийг боловсруулан УНТЭ-ийн захиргаанд хүргүүлсэн. - Цусны миелойд эсийн гаралтай архаг хавдар болон ходоодны GIST хэлбэрийн хавдартай 212 өвчтөний эмчилгээнд байнга хэрэглэдэг хавдрын бай эмчилгээ болох Иматиниб эмийн 2025 оны эхний 2 улирлын хэрэглээ болох 760 хайрцаг 3,4 тэрбум төгрөгийн эмийг АНУ-н хүмүүнлэгийн байгууллагын тусламжаар авч уулгаж, амбулаториор хянаж байна. - Цусны хавдрын бай эмчилгээний II, III эгнээний эмчилгээ болох Акалабрутиниб эмийг 2 тохиолдолд, Понатиниб эмийг 2 тохиолдолд шинээр эмчилгээнд нэвтрүүлж, эмчилгээний дараах 3,6,12 сарын үр дүнг тооцохоор, шаардлагатай үзүүлэлтүүдийг хянаж байна.	70%
4.20	Хэвлийн дурангийн болон толгой хүзүү, урологийн, ерөнхий мэс заслын хорт хавдрын үеийн	Хүзүүний лимфдиссекшн 1 тохиолдол, Хэвлийн дурангаар бөөр авах, булчирхай түүх мэс засал эмчилгээг 3 тохиолдолд тус тус хийж шинэ технологи нэвтрүүлсэн.	70%


5.3	Хөдөлмөрийн сахилга бат, байгууллагын соёл, ажилтнуудын харилцаа хандлагыг сайжруулах сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах - Монголын зөөлөн ур чадварын нийгэмлэг - Монголын Бурханы Шашинтны Төвийн “Лэгмон төв” - Удирдлагын академи - Хувь хүний хөгжлийн институт - Холбогдох төрийн байгууллагуудтай хамтарсан эрх зүйн сургалт	Эмнэлгийн Захиргаа, эмнэлгийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хороо, эмнэлгийн дэргэдэх Ёс зүйн дэд хороо, эмнэлгийн Үйлдвэрчний эвлэлийн хороо хамтран удирдлага манлайлал, харилцаа хандлага, ёс зүй, хөдөлмөрийн сахилга батыг сайжруулах чиглэлд 2025.01.02-2025.06.04-ний хугацаанд нийт 17 удаагийн сургалтыг амжилттай зохион байгуулсан байна. Үүнд: - Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль - Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм - Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ - Манлайлал, түүний хэлбэрүүд - Шинэ цагийн сувилагчийн манлайлал - Эерэг хандлага, бүтээлч сэтгэлгээ - Манлайллын далд хүчин зүйлс - Мартахуйн гайхамшиг - Анхны эерэг сэтгэгдэл төрүүлэх нь - Тогтвортой харилцаа ба итгэлцэл - Стрессээ эергээр удирдах энгийн арга - Шинэ цагийн эмчийн манлайлал - Хүний эрх ба гэмт хэрэг - Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ажилчдын сэтгэцийн эрүүл мэндийг үнэлсэн байдал - Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй ба үнэ цэнэ - Аз жаргалтай ажлын байр сэдэвт сургалтууд болно. Мөн эмнэлгийн ерөнхий захирлын 2025.06.02-ны өдрийн А/172 тушаалаар “УНТЭ-ийн нийт ажилтнуудын хандлага, хариуцлагыг нэмэгдүүлэх” 3 сарын аяныг 2025.06.02-2025.09.02-ны хугацаанд зохион байгуулахаар эхлүүлсэн.	100%
5.4	Шаардлагатай албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж эмнэлгийн захирлаар батлуулна.	УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2024.11.25-ны өдрийн А/371 тушаалаар “Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах” ажлын хэсгийг 24 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгийг Захиргаа, хүний нөөцийн албаны дарга П.Мөнхтуул ахалж, байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөж байгаа нийт 111 албан тушаалын тодорхойлолтыг 5 багт хуваагдан хариуцан боловсруулж байна.	70%



		 Зураг 16. Ажлын хэсгийн А/371 тушаалын нүүр 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар ажлын хэсэг нь нийт 10 нэгжийн 62 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан байна. Үүнд: - ДОТ-9 АТТ - ИБА-9 АТТ - МТА-3 АТТ - МХНТ-2 АТТ - МЭТ-3 АТТ - СЭШХАА-5 АТТ - ЭмЗүйн алба-10 АТТ - ЭМТҮ ЧАБА-1 АТТ - ЭХААҮХТА-14 АТТ - ЭЭСНЛ-6 АТТ тус тус шинэчлэн боловсруулсан.	
5.5	Эмнэлгийн ажилтнуудад хууль эрх зүйн мэдлэг олгох видео хичээлийн цахим сан үүсгэн гадаад дотоод цахим хуудсанд байршуулна.	Захиргаа, хүний нөөцийн алба нь эмнэлгийн хуулийн зөвлөх Ш.Нарантуяатай хамтран “УНТЭ-ийн Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ сэдэвт 23 минутын цахим видео хичээлийг хийн, шинэ ажилтнуудад мэдлэг олгож, таниулан мөрдүүлж, зөрчил үл тохирлоос урьдчилан сэргийлж ажиллаж байна.  Зураг 17. Цахим хичээл	100%
5.6	Шинэ ажилтныг чиглүүлэх, дасан зохицох хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана.	Эмнэлгийн ерөнхий захирлын 2022.01.10-ны өдрийн А/01 тоот тушаалаар “Ажилтан хөгжүүлэх хөтөлбөр”-ийг, 2022.02.21-ний өдрийн А/44 тоот тушаалаар “Шинэ ажилтныг чиглүүлэх, дасан зохицох хөтөлбөр”-ийг тус тус баталж мөрдөн ажиллаж байна.	90%

		Захиргаа, хүний нөөцийн алба нь “Шинэ ажилтанд зориулсан сургалтын удирдамж”-ийн дагуу 2025.04.10-ны өдөр 2025 оны 1-р улиралд ажилд шинээр томилогдсон 15 ажилтан, чөлөөнөөс ажилдаа эргэн томилогдсон 10 ажилтанд 22 сэдэвт хөтөлбөрөөр сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар шинэ ажилтан хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд заавал мэдэх багц мэдээлэл, ажилтан хөгжүүлэх сургалтуудыг танилцуулсан. Байгууллагын хамт олны дотоод хаалттай facebook группэд шинэ ажилтныг дүр төрхийг таниулах, товч CV, мэдээллийг танилцуулж ажиллаж байна.	
		  Зураг 18. Шинэ ажилтанд зориулсан сургалтын удирдамж Зураг 19. Шинэ ажилтны танилцуулга	
5.7	Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллана.	УНТЭ-ийн эрх бүхий албан тушаалтан нь 2025 онд авлигын эсрэг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 чиглэлээр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 52 ажилтан ХАСХОМ, 6 ажилтан урьдчилсан мэдүүлэг гаргасан.	30%
Зорилт 6: Чанарын менежментийн тогтолцоог нутагшуулах /MNS ISO 9001:2016 стандарт/			
6.1	Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага MNS ISO 9001:2016 стандартын мэдлэг сэргээх сургалтыг зохион байгуулна.	Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний компани болох “УАЙ ЭС КОНСАЛТИНГ” ХХК-тай хамтран 2025 оны 05 сарын 20-21-ний өдрүүдэд “Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015” стандартын аудитор бэлтгэх сургалтыг 2 түвшинд зохион байгуулж 109 сувилагч, 124 захиргаа, дэмжих үйлчилгээний ажилтнууд, 80 гаруй эмч сувилагчийг хамруулсан.	100%

		 Зураг 20. Сургалтын явцаас	
6.2	Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага MNS ISO 9001:2016 стандартын аудитын сургалт зохион байгуулж шинэ аудиторуд бэлтгэнэ.	Дээрх сургалтын дараа мэдлэг сорих тест шалгалтад хамруулж, 40 гаруй эмч, сувилагч, захиргааны мэргэжилтнүүд аудитор болох шалгалтад тэнцсэн. УНТЭ-ийн тасаг, нэгж бүрийг чадавхжуулах зорилгоор дахин нэмэлтээр 50 аудиторыг нэмсэн. Нийт 90 эмч, сувилагчийг аудитораар бэлтгэх зорилго тавьж, Зөвлөх аудиторын хамт төлөвлөгөөт хуваарийн дагуу, тасаг нэгжүүдэд дадлага ажил хийж байна. Одоогийн байдлаар 13 аудитор дадлага ажлаа амжилттай хийсэн.  Зураг 21. Аудит хийж буй үйл явцаас	70%
6.3	Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага MNS ISO 9001:2016 стандартын аудитад төв, тасаг, албадыг бүрэн хамруулна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар ISO 9001:2015 стандартын дотоод аудитад 13 төв, тасаг нэгж хамрагдаад байна.	90%
Зорилт 7: Сургалт эрдэм шинжилгээ, судалгаа, гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх			
7.1	“Эрдмийн чуулган - 46” байгууллагын 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулна.	УНТЭ-ийн түүхт 100 жилийн ойн ажлын хүрээнд Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2025.10.23-ны өдөр “УНТЭ-ийн өнгөрсөн, одоо, ирээдүй” урианы дор зохион байгуулахаар ажиллаж байна.	30%
7.2	Эмнэлгийн удирдлагын багийг чадавхжуулах гадаад ба	“Удирдах ажилтны зөвлөгөөн-2025”-д нийт эмнэлгийн 54 удирдах болон зөвлөх албан тушаалтнууд хамрагдсан бөгөөд байгууллагад ирж буй шинэ ажилтнуудын онцлог, тэднийг хэрхэн дасан зохицуулах талаар, мөн удирдлагын дүн шинжилгээ	100%

	дотоодын сургалтыг зохион байгуулна.	хийх арга зүйд суралцаж, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголтод хүрсэн. Мөн УНТЭ-ийн түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар хэлэлцүүлэг хийсэн.  	
7.3	“Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдал” индекс S(s) 091906 чанарын менежер бэлтгэх, сургалтын хөтөлбөр боловсруулж сургалт эрхлэх зөвшөөрөл авна.	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлыг хариуцсан газар (ЭМХЗ)-аас 2025.01.17-ны өдөр баталсан 01 дүгээр тогтоолын дагуу, 2025.03.25-нд Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй “Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдал” хөтөлбөрийн хүрээнд төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалт зохион байгуулах гэрээ байгуулсан. Уг хөтөлбөрийн дагуу 2025.04.01-ний өдрөөс эхлэн Э.Цэрэннадмид, Р.Ганжаргал нар сургалтад хамрагдаж эхэлсэн. 	100%
7.4	“Элэгний эмгэг, урхаг хүндрэлийн менежмент 2025” үндэсний хэмжээний сургалтыг зохион байгуулна.	“Элэгний эмгэг, урхаг хүндрэлийн менежмент 2025” үндэсний хэмжээний сургалтыг 2025.03.17-нд амжилттай зохион байгуулсан. Сургалтад нийт 145 эмнэлгийн мэргэжилтнүүд танхим хэлбэрээр оролцсон ба 117 оролцогч УБ хотоос, 28 нь орон нутгаас оролцсон. Сургалтын ирц өмнөх онтой харьцуулахад 2%-аар өссөн тоон үзүүлэлт гарсан. Гепатологийн чиглэлээр явагддаг энэхүү чухал сургалт дээр салбарын мэргэжилтнүүд өөрсдийн судалгаагаа танилцуулж, дэлхийд гарсан шинэ нээлтүүд, удирдамжуудыг хэлэлцэж, хоорондоо танилцаж, мэргэжлийн харилцаа холбоогоо Зураг 24. Сургалтын хөтөлбөр	100%



		бататгах боломж бүрддэг. Иймээс энэхүү сургалтыг цаашид ч гэсэн жил бүр зохион байгуулж, уламжлалыг улам хөгжүүлэх шаардлагатай байна.  Зураг 25. Сургалт	
7.5	Монголын нефрологийн холбоотой хамтран “Бөөр судлалын үндэсний VI дугаар семинар”-ыг зохион байгуулна.	2025 оны 11 сард зохион байгуулахаар төлөвлөн, бэлтгэл ажлыг хангаж байна.	-
7.6	Суралцагч нарын сургалтын орчныг сайжруулж засвар үйлчилгээ хийнэ.	Дотоод заслын интерьерийн зураг төсөл дээр ажиллаж байна.  Зураг 26. Засварын төлөвлөгөө	30%
7.7	БНСУ-ын “ASAN” эрүүл мэндийн төвд нойр булчирхай шилжүүлэн суулгах давтан сургалтад эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдээ хамруулна.	УНТЭ, БНСУ-ын Асан эрүүл мэндийн төв хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу эхний ээлжийн баг 2025.01.13-2025.01.26 хүртэл элэг шилжүүлэн суулгах мэс заслын үед донор элгийг дурангаар авах үеийн мэдээгүйжүүлэг, мэс засал чиглэлээр МХТН их эмч Г.Одончимэг, ЭШСТ-ийн их эмч Б.Цэрэнбат нар суралцсан. 2-р ээлжийн багт ЭШС мэс заслын үеийн мэдээгүйжүүлэг чиглэлээр МХНТ-ийн их эмч Л.Болормааг 2025.05.01-2025.05.30 хооронд сургалтад хамрагдсан.	70%

		Дараагийн багууд III, IV улиралд элэг шилжүүлэн суулгах чиглэлээр Асан эрүүл мэндийн төвд 5 эмч, 4 сувилагч дадлагажих, мэргэшүүлэх сургалтад хамруулахаар төлөвлөсөн.	
7.8	“WBMT symposium work shop” буюу буюу “Дэлхийн үүдэл эс шилжүүлэн суулгах нийгэмлэг”-ийн Олон Улсын хурлыг зохион байгуулах (36 орны зочид төлөөлөгчид оролцоно)	Дэлхийн цусны үүдэл эс шилжүүлэн суулгах нийгэмлэгийн /WBMT/ 9 дахь workshop уулзалт, сургалтыг 2025.06.26-аас 28-ны хооронд Улаанбаатар хотод “Holiday” зочид буудлын хурлын зааланд зохион байгуулахаар төлөвлөж, санхүүжилт босгон, хөтөлбөрийг боловсруулан, оролцогч, лектор зочдыг тодорхой болгон, хурлын веб-сайтыг нээж, англи илтгэлүүдийг орчуулан, хурлын бусад бэлтгэл ажлуудыг тус төвийн эмч нар тасралтгүй хангаж, 7 хоног тутамд Дэлхийн BMT–н ерөнхийлөгч болон гишүүдтэй онлайн уулзалт хийж байна.    Зураг 27. Олон улсын хурлын хөтөлбөр	70%
Зорилт 8: Цахим эрүүл мэндийн тогтолцооны хөгжүүлэлт, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах, телемедицины үйл ажиллагааг өргөжүүлэх			
8.1	Мэдээллийн аюулгүй байдлын аутсорсинг үйлчилгээ авч аюулгүй байдлын болон эрсдэлийн үнэлгээ хийлгэнэ.	2025.05.05-ны өдрийн 1/702 тоот албан бичгээр үнийн санал авч хамтран ажиллах гэрээ байгуулахаар ажиллаж байна.	50%
8.2	Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO/IEC 27001:2022 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.	Мэдээллийн аюулгүй байдлын аутсорсинг үйлчилгээ авч МАБ-ийн менежментийн тогтолцоо MNS ISO/IEC 27001:2022 стандартыг нэвтрүүлэх ажлыг хангахаар төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.	30%
8.3	Байгууллагын гадаад цахим хуудсыг шинэчилнэ.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагын вэб хуудсыг шинэчлэх ажлыг Содон Солушн ХХК-аар гүйцэтгүүлж байна. Гүйцэтгэлийн ажлыг 2025 оны 07 сард дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.	70%

8.4	Эмнэлгийн үйл ажиллагааны процессыг кодлон автоматжуулах ажлыг эхлүүлэх	ЭМС-ын 2025.03.31-ний өдрийн A/102 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсэг сувилахуйн үйл ажиллагаанд хөтлөгдөж буй бичиг баримтыг кодлох ажил хийж байна. Үүнд ажлын хэсгийн гишүүд 3 багт хуваагдан Зүрхний төв болон ГЭТ-ийн үйл ажиллагаатай танилцаж мөрдөгдөж буй хууль эрхзүйн баримт бичгийн хүрээнд сувилагчийн хөтөлж буй цаасан болон цахим маягтад хяналт хийж, үйл ажиллагааг сайжруулан ажлын давхардал болон маягтын давхардлыг арилгахаар ажиллаж байна.  Зураг 28.. Ажлын хэсгийн тушаал	30%
8.5	МУЗГҮАХ 2.32.6 МУХТ 3.3.15 Телемедициний технологийг ашиглан зайн оношилгоог хөгжүүлэх, дүүрэг, орон нутгийн эмнэлгүүдэд газар зүйн байрлал хамаарахгүйгээр тусламж үзүүлж мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.	Зайн оношилгооны төв 2024.12.17-ны өдөр нээгдсэнээр Рентген, СТ, MRI, Маммографик дүрс оношилгооны зургуудыг орон зай цаг хугацаанаас үл хамааран хөдөө орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудаас чанарын өндөр түвшинд стандартын дагуу хүлээн авч, дүгнэлтийг нарийн мэргэжлийн эмч нар гаргах боломж бүрдсэн. Тус зайн оношилгооны төвд сар бүр УНТЭ-ийн Дүрс оношилгооны төвийн 1 эмч ажиллаж, дүүрэг, орон нутгийн эмнэлгүүдийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна. Одоогийн байдлаар ДОТ-ийн их эмч О.Пүрэвдорж зайн оношилгооны төвд 1 сарын хугацаатай ажиллаж байна.	90%
8.6	МУХТ 3.3.15 Онлайн тусламж амбулаторийн үйлчилгээг өргөжүүлэн үзлэг оношилгооны хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2025.01.03-ний өдрөөс эхлэн Хан-Уул дүүргийн нийт 25 өрхийн эрүүл мэндийн төвтэй MS Teams программыг ашиглан холболт хийж “Онлайн эмнэлэг” төслийг эхлүүлэн хэрх үе судлал, Бөөр судлал, Урологи, Цусны эмгэг судлалын эмчийн үзлэгийг цахим хэлбэрээр нийт 3776 үзлэг хийгдсэн байна. 2025.01.18-ны өдөр ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн бодлогын газраас зохион байгуулсан Онлайн эмнэлгийн үйл ажиллагааг танилцуулах, цаашид авч хэрэгжүүлэх ажлыг танилцуулах сургалтад “Онлайн эмнэлгийн программ хангамж болон хэрхэн холбогдох талаар” сургалтыг нийт Хан-Уул дүүргийн өрхийн эмч нарт хийсэн.	100%


			
Зорилт 9: Гамшгийн үеийн бэлэн байдлыг ханган ажиллах, шинэ болон сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх			
9.1	МУХТЖҮЧ 2.2.1 Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг шинэ болон сэргэж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үзүүлэх сургуулилалт зохион байгуулна.	III улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн.	-
9.2	Эмнэлгийн төв байрны нийтийн эзэмшлийн талбайд галын утаа мэдрэгч, дохиоллын систем, стикер, галын булан тавьж галын аюулгүй байдлыг хангана.	Галын аюулгүй байдлыг хангаж эхний байдлаар 19,5 сая төгрөгийн өртөг бүхий Гал унтраагуур - 90, Гал унтраагуурын суурь - 90, Хяналтын таг - 90, Галын Сарай – 4 иж бүрдэл зэрэг нэн шаардлагатай худалдан авалтыг хийж, төв, тасаг, нэгжүүдэд тараан байршуулсан.	90%
9.3	Галын аюулгүй байдлын сургалтыг Сүхбаатар дүүргийн ОБЕГ-тай хамтран хийнэ.	Сүхбаатар дүүргийн ОБЕГ-тай хамтран эмнэлгийн нийт ажилтанд галын аюулгүй байдлын сургалт хийхээр төлөвлөж, албан бичиг хүргүүлэхээр ажиллаж байна.	30%
9.4	Эмнэлгийн 4 нөөц үүсгүүрийн бэлэн байдлыг ханган ажиллана.	Нэн шаардлагатай төв тасаг нэгжийн цахилгаан хангамжийн гэнэтийн ослын үед ашиглах нөөц үүсгүүрийн бэлэн байдлыг хангаж, мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг “Монхорус интернэшнл” ХХК-тай “Дизель-генератор”-ын үзлэг үйлчилгээний гэрээг байгуулан, улирал тутамд үзлэг үйлчилгээг хийж байна.	100%
9.5	Эмнэлгийн аянга зайлуулагч, газардуулгын болон цахилгаан энергийн хэмжилт хийлгэнэ.	Эмнэлгийн аянга зайлуулагч, газардуулгын болон цахилгаан энергийн хэмжилтийг 2025 оны эхний хагас жилд хийлгэсэн. Протокол, дүгнэлт VI сард гарна.	100%
9.6	Цацрагийн гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн батлуулж	Тус төлөвлөгөөг одоогоор шинэчлээгүй ба ирэх улиралд шинэчлэн батлуулахаар төлөвлөж байна.	-

	хэрэгжилтийг ажиллана.	ханган		
Зорилт 10: Үндэсний хэмжээнд болон эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах				
10.1	МУЗГҮАХ 2.3.1.2 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.	Эрүүл мэндийн сайдын тушаал, заавар, бодлогын бичиг баримтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд иргэд, олон нийтэд мэдээлэл сургалт сурталчилгаа хийн, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж байна. 2025 онд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй дараах арга хэмжээний төлөвлөгөөнүүдээс эрүүл мэндийн байгууллага болон УНТЭ-ийн үйл ажиллагаатай шууд холбоотой доорх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. • “Халдварт өвчинтэй тэмцэх,сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө батлах тухай • “Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай • “Сэтгэцийн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай • “Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх, хамгааллын (2024-2026 он) арга хэмжээний төлөвлөгөө” батлах тухай • “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” (2024-2027 он) төлөвлөгөө батлах тухай		90%
10.2	Дэлхийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлнэ.	УНТЭ-ээр үйлчлүүлж буй үйлчлүүлэгч болон тэдний ар гэр, хэвтэн эмчлүүлэгч нарт зориулан “Зонхилон тохиолдох өвчний үеийн хооллолт, хоол эмчилгээ, илчлэг тооцох арга, илчлэг гэж юу вэ? эрүүл бус хүнсний хэрэглээ”-ний талаар мэдээлэл олгох өдөрлөгийг зохион байгуулсан. Дэлхийн эрүүл мэндийн 9 тэмдэглэлт өдрийн өдөрлөг зохион байгуулсан. Эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор гарын авлага, тараах материал боловсруулан 600 гаруй үйчүүлэгчид тарааж мэдээлэл түгээсэн. 2025 оны эхний 5 сарын байдлаар 9 тэмдэглэлт өдрүүд үүнд: 1. Хорт хавдартай тэмцэх дэлхий өдөр 2. Сонсгол хамгаалах дэлхийн өдрийг 3. Глаукома өвчинтэй тэмцэх дэлхийн долоо хоног 4. Бөөр хамгаалах дэлхийн өдөр 5. Дуу хамгаалах олон улсын дэлхий өдөр 6. Гарын эрүүл ахуйг сахих дэлхийн өдөр 7. Цусны даралт ихсэлтээс сэргийлэх дэлхийн өдөр 8. Дэлхийн хоол боловсруулах эрүүл мэндийн өдөр 9. Дэлхийн тамхигүй өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлж зонхилон тохиолдох өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх мэдээллийг өгөхийн зэрэгцээ тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан 11, 31 дүгээр ЕБС-ийн дунд ангийн 200 гаруй сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулан, эмнэлгээр үйлчлүүлж буй үйлчлүүлэгч нарт нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөөг өгч ажилласан.		90%

		  Зураг 30. Сургалт, өдөрлөг, мэдээллийн явцаас	
10.3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрүүл мэндийн байгууллагаар саадгүй үйлчлүүлэх, мэдээлэл авах боломжоор хангах ажлын хүрээнд ажилтнуудын дунд дохионы хэлний сургалтыг зохион байгуулна.	“Сонсголгүй иргэдийн үндэсний холбоо”-той хамтран эрүүл мэндийн байгууллагад дохионы хэлмэрчийг ажиллуулах, сонсголгүй иргэдийг дэмжих чиглэлээр дохионы хэлний сургалтыг 2025.05.26-ны өдрөөс зохион байгуулсан. Байгууллагын хэмжээнд 29 ажилтан хамруулж, батламж гардуулсан. Сонсголгүй иргэдийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг саадгүй авах боломжийг ханган ажиллаж байна.   Зураг 31. Дохионы хэлний сургалт	100%
10.4	Хүн амд зонхилон тохиолдох өвчин эмгэгээс сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох контент, подкаст бэлтгэж ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг тасралтгүй зохион байгуулна.	Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн Захирлын ажлын алба, Нийгмийн эрүүл мэндийн алба нар удирдан зохион байгуулж тасаг, төвүүдийн эмч мэргэжилтнүүдтэй хамтран ард иргэдийн Эрүүл мэндийн боловсролыг сайжруулах, нийгмийн эрүүл мэндийн зөвлөгөө контент 12-ыг хийж гүйцэтгэсэн нь нийгмийн цахим сүлжээнд УНТЭ-ийн фейсбүүк пэйж хуудсаар дамжуулан 50 мянга гаруй хүнд хүрсэн хандалттай байна.    Зураг 32. Бэлтгэсэн мэдээлэл	100%


УНТЭ-ийн хоолзүйч Э.Санчир

- 2025.02.17-ний өдөр Mongol HD телевизийн Terminal 1.0 нэвтрүүлэгт оролцож хүн амын дундах хооллолт, өвөрмөц бүлгийн хоол шим тэжээлийн талаар “Хүнсний харшил, үл зохицол” сэдвээр зөвлөгөө мэдээлэл өгсөн.
- 2025.05.20-ний өдөр Бүх насны иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох зорилготой хийгддэг Dr.Unuruu podcast-д Эмчилгээний хоол зүй сэдвээр зөвлөгөө мэдээлэл түгээсэн.
- Арслан.мн мэдээллийн сайтаар дамжуулан “Хоолны хордлого, гүйлгэлт суулгалтын үед хэрэглэх хоол хүнс” сэдвүүдээр зөвлөгөө мэдээлэл олгох 3 минутын видео зөвлөмжийг бэлтгэн байгууллагын мэдээллийн сувагт байршуулсан.



Зураг 33.. Ярилцлагын явцаас

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн дунд зонхилон тохиолдож буй өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, дээшлүүлэх зөвлөгөө мэдээллээр хангах ажлын хүрээнд 2022.03.03-нд “Жаргалан” цахим сувагт УНТЭ-ийн НЭМА-ны хоолзүйч Э.Санчир оролцон 30 минутыг нэвтрүүлгийг “Өтгөн хаталтын үеийн эмчилгээний хоолзүй” сэдвээр хамтран бэлтгэж ард иргэдэд хүргэн ажилласан.




Зураг 34. Ярилцлагын явцаас


Монголын радио 76.1 долгионоор 2025.04.17-ны өдөр “Амьдралын хэв маяг ярилцлага- Хоол шим тэжээл сэдвээр мэдээ мэдээлэл түгээн ажилласан.

		 Зураг 35. Ярилцлагын явцаас НЭМА-ны сэтгэц, сэтгэл заслын их эмч А.Оюунжаргал сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор Human Chanel Medic Facebook хуудсыг хамтран хөтөлж 1. "Донтох эмгэг, цахим мөрийтэй тоглоом"-с сэргийлэх 2. "Мэдрэлийн ядаргаа ба нойргүйдэл" 3. "Охид, бүсгүйчүүд, эмэгтэйчүүддээ анхаарлаа хандуулаарай" сэдвүүдээр подкаст хөтлөн оролцож, олон нийтэд эрүүл мэнд, танин мэдэхүйн боловсрол олгон ажиллаж байна.	
10.5	"Эмийн аюулгүй байдлын 7 хоног" арга хэмжээг зохион байгуулна.	IV улиралд хийхээр төлөвлөсөн.	-
10.6	"Бичил биетний тэсвэржилтийн дэлхийн 7 хоног" арга хэмжээг зохион байгуулна.	IV улиралд хийхээр төлөвлөсөн.	-
Зорилт 11: Эмнэлгийн түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх болон хөрөнгө оруулалтын чиглэлээр			
11.1	Эмнэлэг үүсгэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлнэ.	УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2024.11.05-ны өдрийн А/347 тоот "УНТЭ-ийн түүхт 100 жилийн ойн арга хэмжээ, бэлтгэл ажлыг зохион байгуулах тухай" батлагдсан тушаалын дагуу ажлын хэсэг байгуулагдаж, чиг үүргийн дагуу ажлуудыг зохион байгуулж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	70%
11.2	Засгийн газрын дэмжлэгтэй нийлүүлэгдэх эм савлалтын автомат машиныг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.	2025.05.28-нд Эмийн автомат савлалтын машин бүхий агуулахын нэгдсэн систем тендер зарласан. Тендерт шалгарсан Доктор Тун ХХК нь ЭМЯ-тай гэрээ байгуулах шатанд ажиллаж байна. Тус байгууллагатай мэдээлэл солилцон, эмийн ухаалаг программ, эмийн харилцан нөлөөлөл, эмнэлэгт хэрэглэж буй бүх эмийн дэлгэрэнгүй судалгааг хийх, үйл ажиллагааны журам болон бусад бэлтгэл ажлууд хийгдэж байна.	30%
11.3	1971 онд ашиглалтад орсон эмнэлгийн төв барилгын гадна фасадыг шинэчилнэ.	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн барилгын гадна фасадын засварын ажлын тендерийг 2024 онд зарлаж, гүйцэтгэгчээр "Би Рич Трейд" ХХК шалгарч засварын ажлын гэрээг байгуулсан. 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс тус засварыг ажил эхэлсэн бөгөөд 2025 оны VI сард дуусгах төлөвлөгөөтэй явагдаж байна.	70%

11.4	Амбулаторийн хэсгийн хэрэгцээний цэвэр, бохирын усны шугамын засварыг хийнэ.	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Е блокийн цэвэр бохир усны шугам сүлжээ болон эрчимт эмчилгээ, дурангийн өрөөний салхивчны их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/-ын ажлын тендерийг 2024 онд зарлаж, гүйцэтгэгчээр “Түмт мөрөн” ХХК шалгарч, засварын ажлын гэрээг байгуулсан ба гэрээнд заасны дагуу 2025.03.15-ны өдрөөс тус засварыг хэсэгчлэн эхлүүлсэн. Эхний хэсгийн засварын ажил дуусаж байгаа тул Эрүүл мэндийн яам, Барилгын хөгжлийн төвд ашиглалтад оруулах 2025.06.02-ны өдрийн 1/887 дугаартай албан бичиг хүргүүлсэн.	70%
11.5	Шинээр баригдаж буй хүчилтөрөгчийн үйлдвэрийг хүлээж авч ашиглалтад оруулна.	Шинээр баригдаж буй хүчилтөрөгчийн үйлдвэрийн барилгын ажлыг хүлээн авах хүсэлтийг Улсын комисст илгээсэн. II, III улиралд хийхээр төлөвлөсөн.	-
11.6	МУХТ 3.3.11 “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв”-ийн барилга болон “Авто зогсоолын барилга”-ын ажлыг үргэлжлүүлнэ.	“Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв болон Авто зогсоол”-ын барилга угсралтын тендерийг 2024 онд Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт зарлаж, 2024.07.25-ны өдрийн УТ2402002274ХО/99 дугаартай барилга угсралтын ажлын гэрээг Эрүүл мэндийн яам, Магнус Сентурион Констракшн ХХКомпанитай байгуулсан. “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв”-н барилгын суурийн цутгалтын ажил хийгдсэн. Авто зогсоолын барилгын үндсэн цутгалтын ажил дууссан, гадна инженерийн шугамын ажил хийгдэхэд бэлэн болсон. “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв”-н барилгын 8 давхарт байрлах Цус-ВМТ хэсгийн агаарын урсгал зохицуулах өвөрмөц филтерүүдийн байрлал, хими эмчилгээ, үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээний өрөөнүүдийн нарийн зохион байгуулалтуудыг дэлхийн бусад ВМТ төвүүдийн адил орчин үеийн өндөр стандарт бүхий бариулах талаас нь тус төвийн эмч нар барилгын инженерүүдтэй тасралтгүй зөвлөлдөж палан болон 3D зургууд бүрд саналаа тусган байнга хамтран ажиллаж байгаа.	70%
11.7	Төвийн вен, артерийн судсанд гуурс байрлуулах, мэдрэлийн хориг хийж өвдөлт намдаах зэрэг ажилбарын үед хэрэглэгдэх хүчин чадал сайтай сүүлийн загварын ЭХО аппарат авна.	Хүчин чадал сайтай ЭХО аппаратын хэрэгцээг үндэслэж, төсөл бичсэн. Зохих газрууд руу цахимаар хүсэлт явуулсан	30%
11.8	Амбулаторийн 1 давхрын лавлагаа, цахим бүртгэлийн хэсэгт орчин үеийн шийдэл бүхий иж бүрэн засвар хийнэ.	УНТЭ-ийн 100 жилийн ойн арга хэмжээг угтан Амбулаторийн 1 давхарт цахим бүртгэлийн хэсэг, Амбулаторийн эмийн сан, эмийн сангийн агуулах, үйлчлүүлэгчийн өлгүүрийн хэсэг зэрэг нийт 542м ² талбайг 500 гаруй сая төгрөгийн өртгөөр орчин үеийн дэвшилтэт технологиор засаж тохижуулсан.	90%



Зураг 36. Амбулаторийн 1 давхар цахим бүртгэлийн хэсэг засвар



Зураг 37. Амбулаторийн 1 давхрын засварын дараах байдал

Тайланг хянасан:

Захирлын ажлын албаны дарга

[Signature]

/Ц.Амаржаргал/

Тайланг нэгтгэсэн:

Захирлын ажлын албаны
Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн

[Signature]

/Ц.Наранчимэг/

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ.

Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараах бодлогын бичиг баримтуудад тусгагдсан өөрийн эмнэлгийн чиг үүрэгт хамааралтай арга хэмжээнүүдийг тусгасан болно. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр (МУЗГҮАХ)
2. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (МУТЖҮЧ)
3. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө (МУХТ)
4. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/609 тоот тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө”

2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үйл ажиллагааны **11** чиглэлээр **85** ажил төлөвлөсөн. Үүнд:

- 2025 онд шинээр төлөвлөсөн **49** ажил /59%/
- 2024 оноос үргэлжлүүлэн хэрэгжүүлэх **18** ажил /21,7%/
- Тогтмол зохион байгуулдаг **16** ажил төлөвлөсөн. /19,3%/

Эдгээр ажлуудаас 2025 оны эхний хагас жилийн төлөвлөлтөд ороогүй нийт **8** ажил байна. /4.11, 5.2, 7.5, 9.1, 9.6, 10.5, 10.6, 11.5/

Иймд Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын 6.1 болон 6.2-т заасан аргачлалын дагуу үнэлэхэд эхний хагас жилийн байдлаар **77** ажлын гүйцэтгэлийн дундаж **69** хувьтай байна. Гүйцэтгэлийг зорилтоор авч үзвэл:

- Зорилт 1: Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх 7 ажлын дундаж биелэлт - **58,6%**
- Зорилт 2: Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах 8 ажлын дундаж биелэлт - **77.5%**
- Зорилт 3: Санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, нөөцийн удирдлагыг сайжруулах 5 ажлын дундаж биелэлт - **50%**
- Зорилт 4: Оношилгоо, эмчилгээ, сувилахуйн дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэн нутагшуулах 20 ажлын дундаж биелэлт - **66%**
- Зорилт 5: Хүний нөөцийн хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх 6 ажлын дундаж биелэлт - **73.3%**
- Зорилт 6: Чанарын менежментийн тогтолцоог нутагшуулах /MNS ISO 9001:2016 стандарт/ 3 ажлын дундаж биелэлт - **86.7%**
- Зорилт 7: Сургалт эрдэм шинжилгээ, судалгаа, гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх 7 ажлын дундаж биелэлт - **71.4%**
- Зорилт 8: Цахим эрүүл мэндийн тогтолцооны хөгжүүлэлт, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах, телемедицины үйл ажиллагааг өргөжүүлэх 6 ажлын дундаж биелэлт - **61,7%**
- Зорилт 9: Гамшгийн үеийн бэлэн байдлыг ханган ажиллах, шинэ болон сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 4 ажлын дундаж биелэлт - **80%**
- Зорилт 10: Үндэсний хэмжээнд болон эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах 4 ажлын дундаж биелэлт - **95%**
- Зорилт 11: Эмнэлгийн түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх болон хөрөнгө оруулалтын чиглэлээр 7 ажлын дундаж биелэлт - **64.2%** байна.